



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20¹⁷... оны ¹⁰... дугаар
сарын ²⁷...-ны өдөр

Дугаар Х.ЭГ/1584

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийх болсныг Танд үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолд “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дүгнэж, хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус үүрэг болгосны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2017 оны эхний 9 сарын байдлаар гарган танилцуулж байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт үндсэн хоёр стратеги, зургаан зорилтын хүрээнд нийт 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 2018 оны эхний хагас жилд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ тухайн арга хэмжээний хэрэгжилтийн явц, хэрэгжилтэд учирч байгаа бэрхшээл, биелэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийгдэж байгаа болон цаашид шийдвэрлэх шаардлагатай ажлууд зэргийг харгалзан үзсэн.

2017 оны эхний 9 сарын хэрэгжилтийг авч үзвэл, нийт 54 арга хэмжээнээс:

- 6 арга хэмжээ бүрэн биелсэн;
- 25 арга хэмжээ 70 хувь биелсэн;
- 22 арга хэмжээ 40 хувьтай биелсэн бол 1 арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа болоогүй байна. Хөтөлбөрийн хэрэгжилт дунджаар 60.9 хувьтай байна.

Бүрэн буюу 100 хувь биелсэн зорилт, арга хэмжээг дурдвал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийж, сангийн зарцуулалтыг ард иргэдэд нээлттэй, ил тод болгох;
- Дотоодын зах зээлийг тарифын болон тарифын бус аргаар хамгаалах, дотоодын худалдан авалтыг бодлогоор дэмжиж, хууль, эрх зүйн орчныг бий болгох;
- “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж, батлуулах;
- Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх, дахин санхүүжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж, ажиллуулах зэрэг.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн нэгдүгээр стратеги болох макро эдийн засгийг тогтворжуулах бодлогын хүрээнд ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсан. Үүний үр дүнд макро эдийн засгийг богино хугацаанд

тогтворжуулахад чиглэсэн сангийн болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, шинэчлэл хийсэн нь эдийн засагт эерэг үр дүнг өгч байна.

Хөтөлбөрийн зорилт 1-д **“Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах”** бодлогыг тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан: Олон төсвүүдийг нэгтгэх, цэгцлэх, төсвийн нэгдмэл байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, сахилга батыг сайжрууллаа. Үүний үр дүнд 2017 оны 9 дүгээр сард төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр буурч 737.8 тэрбум төгрөг болсон.

Хөтөлбөрийн зорилт 2-т **“Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцийн тогтвортой байдлыг хангах”** бодлогыг тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан: Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих зөвлөлийг байгуулснаар хөрөнгө оруулагчид эрхээ хамгаалуулах, тулгамдаж байгаа асуудлаараа Засгийн газарт хандах боломж бүрдсэн. Мөн ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр болсон нь манай улсын эдийн засаг, тогтвортой байдалд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалт, олгох зээлийн хэмжээ нэмэгдэх хөшүүрэг болж байна. Үүний үр дүнд бага хүүтэй эх үүсвэр татах, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Тухайлбал, Азийн хөгжлийн банкнаас 100 сая ам.доллар, ОУВС-аас 38.4 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл орж ирээд байна. Цаашид Япон улс 850 сая ам.доллар, БНСУ 750 сая ам.доллар, Энэтхэг улс 1 тэрбум ам.долларын бага хүүтэй зээлүүдийг олгохоор болоод байна.

Хөтөлбөрийн зорилт 3-т **“Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх”** бодлогыг тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан: Монгол Улсын нийт гадаад валютын албан нөөц 2016 оны 10 дугаар сард 1,038.0 сая ам доллар болж, 2009 оны 9 дүгээр сараас хойш хамгийн доод хэмжээнд хүрээд байв. Гадаад валютын нөөц хомсдолтой байсан хэдий ч холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гадаад валютын албан нөөц 2017 оны 10 дугаар сарын байдлаар 1,750.2 сая ам.долларт хүрээд байна. Засгийн газрын баталгаатайгаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2012 онд гаргасан 580.0 сая ам.долларын бондыг хуваарийн дагуу амжилттай эргэн төлсөн нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээлээ.

Хөтөлбөрийн зорилт 4-т **“Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх”** бодлогыг тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан: “Атрын-III аян”-ыг үргэлжлүүлж, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эхлүүлж хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлж байна. Тухайлбал, улсын хэмжээнд хуурай сүүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх бодлогыг хэрэгжүүлж, хуурай сүүний үйлдвэрүүдийг барьж байгуулан, энэ чиглэлийн импортыг бууруулах нөхцөл бүрдээд байна. Тухайлбал, 2017 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Хөвсгөл аймгийн Их-Уул суманд хуурай сүүний үйлдвэр ашиглалтад орсон бол мөн Хэнтий аймгийн

Баянхутаг, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд үйлдвэрүүд ашиглалтад орохоор хүлээгдэж байна. Цаашид хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох бодлогын хүрээнд ОХУ-ын мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран малыг эрүүлжүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрийн зорилт 5-д **“Бодит салбарын өсөлтийг дэмжиж, томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх”** бодлогыг тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан. Тухайлбал, голлох экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ажлын цагийг уртасгах, тээвэрлэлтийн замыг сайжруулах зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсний үр дүнд экспортын хэмжээ 2017 оны эхний 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 37.5 хувиар өсөж, эдийн засгийн идэвхжлийг сайжруулж чадлаа. Засгийн газраас ажлын байраар дамжуулан иргэдийн амьжиргааг сайжруулах, эдийн засгаа сэргээх бодлогын хүрээнд иргэдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан ажлын байр нэмэгдүүлэх, бизнесийн төсөл, хөтөлбөрүүд эхлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд ажилгүйдлийн түвшин 2017 оны 2 дугаар улирлын байдлаар 9.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.8 нэгжээр буурлаа. Мөн 2016 оны 3 дугаар улиралд -1.6 хувьд хүрч унаад байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2017 оны 2 дугаар улиралд 5.3 хувьд хүргэлээ.

Хөтөлбөрийн зорилт 6-д **“Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль, эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх”** бодлогыг тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж байна. Мөн Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай, Активын удирдлагын институцийн тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгээд байна.

Ийнхүү Засгийн газраас нэн тэргүүнд эдийн засгийн уналтыг зогсоох, макро эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулах, цаашид эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр оновчтой бодлогыг авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын эдийн засагт олон эерэг үр дүн гараад байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 2 дугаар хавсралтад тусгасан тэргүүн ээлжид боловсруулж, батлуулах шаардлагатай 13 хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн хэрэгжилтийг дүгнэж үзвэл:

- 4 арга хэмжээ 100 хувь буюу бүрэн биелсэн;
- 8 арга хэмжээ 70 хувь биелсэн;
- 1 арга хэмжээний хэрэгжилт 40 хувьтай байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөр болон ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, гадаад зах зээлийн таатай нөлөөгөөр эдийн засагт эерэг хандлага ажиглагдаж байгаа боловч Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засаг, нийгэмд томоохон нөлөө үзүүлэх эдийн засгийг эрчимжүүлэх зарим төсөл, арга хэмжээний биелэлт хангалтгүй түвшинд байна.

Иймд тэдгээр төслийн санхүүгийн эх үүсвэрийг яаралтай шийдвэрлэх, холбогдох гэрээ, хэлцлүүдийн явцыг түргэсгэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр шуурхай ажиллаж, хэрэгжилтийн тайланг хийгдсэн ажлын гүйцэтгэлд суурилан бодитой, нарийвчлан тайлагнах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал:

Уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр:

- Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах, Дулаан хар уулын холимог металлын уулын баяжуулах, Ширэн Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах, Хар Овоогийн уулын баяжуулах зэрэг төслүүдийн хэрэгжилт удаашралтай байна. Иймд төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төслийн хэрэгжилтэд учирч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлээр тусгайлан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээний биелэлт хангалтгүй байна. Газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээ 2017 оны эхний 9 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурсан байна.
- Тавантолгойн ордод түшиглэн олборлон баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах төслийн хэлэлцээрийг эцэслэн гэрээг байгуулж, хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын явц хангалтгүй байна.
- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулагчийг сонгох, төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах ажлууд удаашралтай байна. Төслийн ТЭЗҮ-д тодотгол хийх арга хэмжээг 2017 оны сүүлийн хагаст бүрэн хэрэгжүүлэхээр тусгасан боловч одоогоор төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Дулааны III цахилгаан станц, Чойбалсангийн ДЦС төслүүдийн санхүүжилтийн хэлбэрийг тодорхой болгоогүйн улмаас ажлын явц зогсонги байдалтай байна. Иймд Дулааны III цахилгаан станц болон Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөлийн хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийг тодорхой болгох, төсөвт дарамт учруулахгүйгээр, үр ашиг өндөртэй байхаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.
- Тавантолгойн 450 Мвт-ын цахилгаан станц барих төслийн хүрээнд хийгдэх цахилгаан худалдах, худалдан авах гэрээний хэлэлцээр удаашралтай байна.

Зам, тээврийг хөгжүүлэх чиглэлээр:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг тодотгох ажлыг 2017 оны эхний хагаст боловсруулж дуусгахаар тусгасан боловч одоог хүртэл ТЭЗҮ-ийг тодотгон боловсруулаагүй байна.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2018 оны эхний хагаст дуусгахаар төлөвлөсөн боловч хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон байна.
- Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам болон Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын царигийн асуудлыг Улсын Их Хурлаар яаралтай батлуулж төслүүдийн барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр ажиллаж байна.
- Хөөт-Бичигт, Зүүнбаян-Ханги, Богдхан төмөр зам барих төслийн санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр:

- Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах ажлууд хугацаандаа хэрэгжээгүй байна. Иймд эдгээр хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын намрын чуулганаар яаралтай хэлэлцүүлэн батлуулах чиглэлээр ажиллаж байна.
- “Ноолуур”, “Малыг эрүүлжүүлэх” зэрэг хөтөлбөрийг 2017 оны эхний хагас жилд шинэчлэн боловсруулахаар тусгасан боловч одоогоор Засгийн газарт танилцуулагдсан хөтөлбөрийн төсөл байхгүй байна.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн загвар үйлдвэрийг бий болгох арга хэмжээг 2017 оны эхний хагас жилд авч хэрэгжүүлэх боловч уг арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.
- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах 12 үйлдвэр байгуулах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлж, хэрэгжилтийн үнэлгээ, тайлагналтыг сайжруулах чиглэлээр холбогдох сайд нарт үүрэг даалгавар, чиглэл өгч ажиллаж байгаа бөгөөд цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр томоохон ажлын хэсэг байгуулан ажиллахаар төлөвлөөд байна.

Хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээний биелэлт, ажлын явцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

УИХ-ын 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-г тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт, ажлын явцын талаарх мэдээлэл

Д/Д	Зорилт	Арга хэмжээ	Зорилт, арга хэмжээний биелэлт	Үнэлгээ, хувиар	Хугацаа
1	1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн боллого хэрэгжүүлнэ	1.1.1. Төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, үр дүнгээр санхүүжүүлэх, төсвийн норм, нормативыг баримтлан хэмнэлтийн горимд шилжих;	ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд нэн тэргүүнд төсвийн нэгдмэл байдлыг бодитойгоор хангах, сахилга батыг чангатгах, төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахаар зорьж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр татварын бодлогын хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтсоны дотор хадгаламжийн хүүгийн орлоготод татвар ногдуулах, хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгох, суудлын автомашин, согтууруулах ундаа болон тамхины онцгой албан татварыг нэмэх, импортын тамхинд ногдох гаалийн албан татварыг нэмэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Түүнчлэн төсвийн тэнцвэртэй байдлыг хангах замаар өрийн дарамтыг үе шаттай бууруулах зорилгоор төсвийн зардлыг бууруулахад нийгмийн хамгаалал, халамжийг хавтгайруулахгүй буюу хүн амын орлого багатай эмзэг хэсэгт түлхүү чиглүүлэх, хүн ам зүйн бүтэц болон хууль, эрх зүйн орчны өөрчлөлтийн улмаас ойрын ирээдүйд төсөвт үүсэх зардлын дарамтыг бууруулах, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг орлогын боломжтой уялдуулан авч үзэх, удирдлагын зардлыг шарцаах, үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан холбогдох арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.	70	
2		1.1.2. “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” багтах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авч ЗГХЭГ-г 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 4-3/4784 тоотор хүргүүлсэн боловч ЗГХЭГ-ын зүгээс жил бүрийн төсөвт хэмнэлтийг суулгах боломжтой тул хөтөлбөр багтах шаардлагагүй гэж үзсэн болно. Төсөлд 2014 оноос хойш УИХ, Засгийн газраас төсөв хэмнэх талаар гаргасан шийдвэрүүдийг судлан, төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулах зорилгоор бараа, ажил, үйлчилгээний зарим зардлуудад хэмнэлтийн хязгаарлалт тогтоож мөрдүүлэхээр 13 заалт бүхий арга хэмжээг тусгаад байна.	Эдгээрийн үр дүнд Монгол Улсын нэгдсэн төсвийн гэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2017 онд 9.9 хувь, 2018 онд 8.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар тооцоод байна. Боловсролын салбарт улсын төсвийн төлөвлөлт, санхүүжилтийг сайжруулах зорилгоор 1-т боловсролын салбарын багшаас бусад ажилтнуудын орон тооны жишиг нормативыг баталгаажуулж мөрдүүлэх, 2-т Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсвийн төлөвлөлтийн хөтөлбөр зориулалтын үр дүнг тооцох аргачлал, бүрэлдэхүүнийг баталгаажуулах /зориулалт бүрт ямар арга хэмжээ, эдийн засгийн ангилууд багтах гэх мэт/ ажлууд хийгдэж байна. Төрийн албан хаагчид олгох нэмэгдэл цалин хөлсийг тогтоох, олгохтой холбоотой гарах тогтоол, шийдвэрийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016 оны 408/А-296 дугаартай тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг ТЭЗ-даас цалингийн нэмэгдэл болон нэмэгдлийн хэмжээг тогтоосон эрх зүйн актуудын судалгааг загвар маягтаар авч нэгтгэн судалгаа хийж, холбогдох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ТЭЗ болон Төрийн албаны зөвлөлөөс санал авсан.	70	

3	<p>1.1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийж, сангийн зарцуулалтыг ард иргэдэд нээлттэй, ил тод болгох</p>	<p>Сангийн яамнаас аймаг, нийслэл, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2013-2016 оны санхүүжилтийн төлөвлөгөө, зарцуулалтын гүйцэтгэлийн мэдээллийг авч дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, байгаль орчны экосистемийг хамгаалах зэрэг эдийн засгийн ач холбогдолтой хөрөнгө оруулалт хийдэггүй байна гэсэн дүгнэлтийг гаргаж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.tusuv-ogonniag.mn цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. Үүнд, тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн мэдээлэл, төлбөр санхүүжилтийн явц, тендерийн мэдээлэл, төсөл арга хэмжээний тодорхойлолт буюу хүчин чадал, төсөвт өртөг, гэрээний дүн, тухайн онд санхүүжих дүн, холбогдох тушаал шийдвэрийн дугаар, фото зураг, зэрэг шаардлагатай мэдээллийг багтаасан. Мөн иргэд, олон нийт тухайн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал гомдлоо илэрхийлэх боломжийг энэхүү системээр дамжуулан олгоод байна.</p>	100
4	<p>1.1.4. Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барьцуулах</p>	<p>2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аар 2017 оны 4 дүгээр сард батлуулав. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 2016 онд санхүүжилдээгүй 14,856.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тусгасан. 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн яамны төсөлд 3.1 тэрбум төгрөг, БСШУС-Яамны төсөлд 1.9 тэрбум төгрөг, ЗТХЭГ-ын төсөлд 1.7 тэрбум төгрөг, ЗТЯамны төсөлд 2.2 тэрбум төгрөг, БХБЯ-нд 504.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна. 2017 оны төсвийн тодотголд шүүхийн шийдвэргүй 13 төсөл, арга хэмжээний 32.9 тэрбум төгрөгийг тусгаж УИХ-д өргөн бариад байна.</p>	70
5	<p>1.1.5. Засгийн газрын үнэт цаасны арилжааг тогтмолжуулах, Хөрөнгийн биржээр дамжуулан борлуулах, үнэт цаасны зуучлагч компаниудын оролцоог нэмэгдүүлэх</p>	<p>Сангийн яам, СЗХ, “Монголын хөрөнгийн бирж” ХК хамтран ЗГҮЦ-ны итгэмжлэгдсэн дилерийн зуучлагчдыг бий болгох, өгөөжийн жишиг хүүгийн муруй /bond yield benchmark/-г бий болгох замаар хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалагдах ЗГҮЦ-ны нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэн, тогтмолжуулах хүрээнд Засгийн газрын үнэт цаасны зах зээлийн байдалд судалгаа хийж, ААН-үүдэд тулгамдаж буй асуудлуудын талаар холбогдох зарим арга хэмжээг шийдвэрлээд байна. Манай улстай ижил төстэй болон бүс нутгийн Азийн орнуудын зохицуулалтын орчны талаарх холбогдох судалгааг хийж, олон улсын зохицуулагч байгууллагаас тогтоосон стандарт, зөвлөмжид үндэслэн үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн танилцуулга, үндэслэлийг боловруулаад байна.</p>	70
6	<p>1.1.6. Дотоодын зах зээлийг тарифын болон тарифын бус аргаар хамгаалах, дотоодын худалдан авалтыг бодлогоор дэмжиж, хууль эрх зүйн орчныг бий болгох</p>	<p>Гаалийн тариф, гаалийн татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуулийн төслийг батлуулав. Гаалийн тариф, гаалийн татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Импортын барааны гарал үүслийн дүрэм” шинэчлэн батлуулав.</p>	100

2017-2018 оны
эхний хагас
жилд

7	<p>1.1.7. Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах</p>	<p>Хөрөнгийн зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлэгч болон зах зээлд оролцогч иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд татварын хөнгөлөлт, урамшуулал зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан үзэж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд хөрөнгийн зах зээлийн нийлүүлэлтийг дэмжих шинээр үнэт цаас гарган нээлттэй болж байгаа хуулийн этгээдийн хувьцаа, өрийн хэрэгслийг Арилжаа эрхлэх байгуулагад бүртгүүлсэн өдрөөс нь эхлэн тодорхой хугацаанд татвараас чөлөөлөх, хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж буй компанийн өрийн хэрэгсэл /бонд/-ийн хүү, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг татвараас чөлөөлөх тухай нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. “Зохицуулалттай зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийн ерөнхий журам”-ын төслийг боловсруулан олон нийтээс санал авч Сангийн яаман дээр ОУВС-гийн хөтөлбөртэй холбоотойгоор хуулийн төслүүдийг судалж байна. Монголбанк, СЯ, БСШУСЯ, СЗХ хамтран баталсан "Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн хүрээнд "Хувь хүний санхүү" хичээлийг- их дээд сургуулиудад судлах боломжтой болж хичээлийн сурах бичиг, дасгал ажлын дэвтэр хэвлэгдэж бэлэн болсон. Энэхүү хичээлийг одоогийн байдлаар ХААИС, ЭГУГЭН, Улаанбаатар эрдэм, СЭЗИС-ууд 2017 оны хичээлийн жилээс эхлэн хөтөлбөртөө албан ёсоор оруулахаар болов. "Бизнес судал" хичээлийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хөтөлбөрт оруулсан. 10-р ангийн сурагчдад Бизнес судлал сонгон судлах хичээлийн сурах бичгийн редакторын ажлыг БСШУСЯ-аар хянуулж, хэвлэлийн эх бэлтгэх ажлыг гүйцэтгэв.</p>	70
8	<p>1.1.8. Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг татвар, зээлийн болдогоор дэмжих</p>	<p>2017 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 20.0 тэрбум төгрөгийн жижиг зээл олгохоор төсөвт багтагдсан. Жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх арилжааны банкыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж Голомт банктэй гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 4.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичиг, жижиг аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоонд жижиг зээлийг олгож байна. Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн боллого хэрэгжүүлж, орон нутгийн санаачлагыг дэмжих хүрээнд Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулж дэмжилгэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан. Эдгээр зорилтот төслийн төсөвт өртгийн дээд хязгаар 200 хүртэл сая төгрөг байх бөгөөд тухайн жилийнхээ багтагдсан төсөвт багтаан 15-с доошгүй төслийг санхүүжүүлж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>	70
9	<p>1.1.9. Концессоор хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд шалгалт хийж, цашид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх механизмг хөрөнгө оруулагч нарт тодорхой болгох</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-аас концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр 2.1 их наяд төгрөгийн 41 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: Боловсролын салбарт 18, Эрчим хүчний салбарт 4, Зам, тээврийн салбарт 16, Дэд бүтэц салбарт 2 төсөл, Эрүүл мэндийн 1 төсөл. УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоол, Олон улсын валютын сангай тохирсон болдогын арга хэмжээний дагуу Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөл, арга хэмжээг улсын төсөвт нэгтгэж, төсвийн нэгдмэл боллого, сахилга батыг хангасан. УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолд "улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах", "төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралт болгон батлахтай холбоотойгоор төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх үе шатанд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай бол төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж туссан.</p> <p>"Барих-Шилжүүлэх" нэхлэлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай</p>	

10	1.2. Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний боллого хэрэгжүүлэх	1.2.1. Активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх	<p>хуулийн хавсралтаар батлах болсонтой холбогдуулан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байх. 2017 оны төсөвт концессоор хэрэгжүүлсэн “Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам” төсөл, “Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам” төслийн гүйцэтгэгчтэй уулзаж төслийн явц, гүйцэтгэлийн талаар тодруулга авч, ирүүлсэн гүйцэтгэлийг хянан “Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам” төсөлд 10.5 тэрбум төгрөг, “Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам” төсөлд 16.1 тэрбум төгрөг, нийтдээ 26.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. “Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг яамд, агентлаг, холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулсан. Төсвийн тухай хуулийн 33.2.9-д “Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөл”, Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын төслийг боловсруулахтай холбогдсон харилцааг Төсвийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.” гэж тус тус заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 4-ны өдрийн А-103 дугаар тушаалаар Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яамны төлөөлөл оролцуулан байгуулж холбогдох яамдаас санал авч, яамдтай нэг бүрчлэн уулзалт хийж, концессын зүйлийн жагсаалтын төслийг эцэслэн боловсруулж, Сангийн яаманд 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01/743 тоогоор хүргүүлсэн. Сангийн яамны зүгээс концессын жагсаалтыг 2018 оны төсвийн тухай хуультай хамт өргөн барьж, батлуулахаар ажиллаж байна.</p>	70
11	1.2.2. Эдийн засгийн болит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хаган боллого хэрэгжүүлэх, банкны системийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд байлгах	1.2.2. Эдийн засгийн болит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хаган боллого хэрэгжүүлэх, банкны системийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд байлгах	<p>Санхүүгийн тогтвортой байдлыг зөвлөлөөс “Активын удирдлагын мэргэшсэн институцийг бий болгох” ажлын хэсэг байгуулсан ба ажлын хэсгийн гишүүдээс бүрдсэн 4 дэд ажлын хэсэг байгуулагдсан. Дагалдан гарах хууль тогтоомжийг боловсруулах, журам, заавар боловсруулахаар ажиллаж байна. Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл боловсруулсан, Сангийн яам ОУВС-тай хийсэн хэлэлцээрийн хүрээнд хуулийн төслийг судалж байна.</p> <p>Сангийн яам, Монгол банк хоорондын ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2008 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 129/133 тоот тушаалаар батлагдсан “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг шинэчилсэн. Инфляци болон макро эдийн засгийн одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн төлөвийг тодорхойлохдоо ирэх жилүүдэд хийгдэх хөрөнгө оруулалт, ОУВС-ын хөгөлбөрийн хүрээнд төсөв, мөнгөний боллогын арга хэмжээнүүд зэргийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсны үндсэн дээр суурь төсөөллийг боловсруулж, макро эдийн засгийн үүсч болзошгүй эрсдэл болон өмнөх төсөөлөө зөрөө зөрүүг тайлбарлаж, мөнгөний боллого тусгаж байна. 2017 оны 3 дугаар сарын боллогын саналд суурь төсөөлөөс гадна боллогын хүүг харгалзан 1, 1.5 нэгж хувиар бууруулах болон экспортын зарим барааны үнэ буурахад эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцон альтернатив хувилбаруудын нөлөөллийг тооцож боллогын саналд тусгасан. Мөнгөний боллогын зөвлөл 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж мөнгөний боллогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан. 2017 оны 5-6 сард суурь төсөөлөл дээр нэмж боллогын хүүг харгалзан 1, 2 нэгж хувиар бууруулах, хүүний корридорыг тэгш хэмтэй болгох болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэг нэгжээр нэмэгдүүлэхэд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцон альтернатив хувилбаруудыг</p>	70

12	<p>1.2.3. Валютын урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй байх, дунд, урт хугацаанд валютын нөөцийг тогтвортой байлгах, хамгаалах зарчим баримтлах</p>	<p>болговруулсан. 2 дугаар улирлын ээлжит хурал 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж мөнгөний боллогын хүүг 2 нэгж хувиар бууруулан 12 хувь болгох, Мөнгөний боллогын “хүүгийн коридор” системийг Монголбанкны боллогын хүүгийн хувь хэмжээнээс +2, -2 нэгж хувиин өргөнөөр тэгш хэмтэйгээр шинэчлэн тогтоох шийдвэрүүдийг гаргасан. 2017 оны 9 дүгээр сарын Мөнгөний боллогын зөвлөлийн хурлаар инфляцийг дунд хугацаанд зорилгот түвшний орчимд тогтворжуулах, улмаар макро эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой нийтлэж байгаа тул мөнгөний боллогын төлөвийг хэвээр хадгалах шийдвэр гаргасан. 2017 оны 8 дугаар сарын байдлаар банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 17.6 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 43.3 хувь байгаа нь Монголбанкны тогтоосон зохистой харьяаны доод хэмжээнээс 5.6 болон 18.3 нэгжээр тус тус өндөр байна.</p>	/0
13	<p>1.2.4. Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, “Үнэ тогтворжуулах” хөгөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад шалгалт хийж, дүгнэлт өгөх</p>	<p>Валютын захын дэд бүтцийг сайжруулах, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, спот ханш бүрдэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Банк хоорондын валют арилжааны цахим талбар”-ыг 2017 оны 4-р сарын 10-ны өдрөөс туршилтын журмаар нэвтрүүлж, албан ёсны нээлтийг 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан. “Монголбанкнаас банк хоорондын валют арилжааны цахим талбарт оролцох журам”, “Монголбанкнаас банк хоорондын цахим талбарт Үндсэн дилерээр дамжуулж арилжаа хийх гэрээ”-г багтаад байна.</p> <p>Мөн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар банк, ААНБ болон бусад байгууллагууд оролцох боломжтой арилжааны нэгдсэн платформ /АНП/-ыг нэвтрүүлэхээр хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг нь АНП-ын програм хангамжийн шаардлагыг судалж, боллогын даалгаврыг боловсруулан програм ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 51 банк бус санхүүгийн байгууллагаас сар, улирлаар валют арилжааны мэдээ зэрэг тайлан мэдээг гаргуулан авч зайны хяналт тавьж мөн хяналт шалгалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж байна.</p> <p>Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцсон. 2017 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар оны эхнээс нийт 64 удаагийн гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, Монголбанкнаас цэрвэрээр 125.4 сая ам.долларыг банкуудаас худалдан авч, 114 сая юань буюу 16.4 сая ам.доллартай тэнцэх юунийг нийлүүлсэн байна. Тайлант хугацаанд Монголбанк арилжааны банкуудтай нийт 34.5 сая ам.долларын богино хугацааг ам.долларын своп хэлбэр, 77.0 сая ам.долларын урт хугацааг своп хэлбэрийг тус тус байгуулсан.</p>	70
13	<p>1.2.4. Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, “Үнэ тогтворжуулах” хөгөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад шалгалт хийж, дүгнэлт өгөх</p>	<p>ХХААХҮ-н сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А-38 дугаар тушаалаар байгуулагдсан 1 дүгээр дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 3Г-ын 2015 оны 149, 171 дүгээр тогтоолын хүрээнд олгогдсон зээлийн хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргасан. Уг дүгнэлтээр эргэн төлөлт удаашралтай 8 ААН, зөрчилтэй 3 ААН илэрсэн. Хөгжлийн банкнаас зээл авсан 9 үйлдвэр 2 мянган тн түүхий ноолуур бэлтгэсэн ба олоо хэвийн жилд ажиллаж байна. Зээл авч ашигласны үр дүнд 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1281 сая ширхэг сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 84.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний экспорт хийгдсэн ба үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 112 хувь, экспорт 119 хувь тус тус өссөн байна. /Арьс ширний 57 үйлдвэрт 86.0 тэрбум төгрөгийн зээл олгогдож, зориулалтын дагуу явагдаж байгаагаас Мон мастер ХХК сүүлийн 2 сар зээлээ төлөөгүй. Эргэн төлөлтөд хүндрэл учирсан. Мон Ит Булггар ХК зээлийн зарцуулалтын тайлангаа ирүүлээгүй байна. Газар тариалангийн 92 ААН-д 23.5 тэрбум төгрөгийн зээл олгогдоноос Голомт банкнаас зээл авсан 6 ААН-ийн зээлийн эргэн төлөлт 35-90 хоногийн хэтрэлттэй байна. Чингис бондоос хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 30 ААН 27.3 тэрбумт-ийн зээл авсан ба 19 ААН-ийг шалгахад 1-ААН зээлээ бүтэн талж лувссан иргэн Ж Түвшинжавгал 170 0 саят-ийн зээл авсан боловч газар шийтгэлгүйг</p>	

<p>улмаас хүлэмжээ байгуулаагүй байна. 6-ААН-ийн эргэн төлөлт удааширч эхэлсэн байна. Махны 4 үйлдвэрүүдэд олгосон зээлийн ашиглалтын шалгалтаар 2 ААН ХХААХҮЯамтай болдогын гэрээ байгуулаагүй байна.</p>	<p>Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслүүдэд үнэлгээ хийж, эрсдэлийг тооцоолох, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаарх арга хэмжээг холбогдох зээлийн гэрээнд заасны дагуу үе шаттай авч хэрэгжүүлэхээр Сангийн Яам болон Хөгжлийн банкнаас тус тус төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу зээлийн хяналтыг тавих, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн багцад анхаарч ажиллах, зөрчилтэй зээлдэгчидтэй хамтран ажиллах замаар эргэн төлөлтийг хангуулах, Хөгжлийн банкны бонд, зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлэх зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>2012-2016 онд зээл авсан байгууллагуудад 2017 оны 2 дугаар сарын 03-наас 20-ны өдрүүдэд 21 аймагт ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгогдсон зээлийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийсэн. Нийт 381,488.3 сая төгрөгийн санхүүжилт авсан 2154 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах байснаас 197,672.0 сая төгрөгийн санхүүжилт авсан 1324 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай танилцсан.</p> <p>197,672.0 сая төгрөгийн санхүүжилт авсан 1324 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай танилцах явцад 2,320.5 сая төгрөгийн санхүүжилт авсан 22 төсөл хэрэгжүүлэгч зээлийг зориулалтын бус ашигласан зөрчил илрүүлээд байна. Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, цашид Засгийн газарт шилжүүлэх талаар Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолыг тус тус гаргуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор албан хүсэлтийг холбогдох байгууллагуудад удаа дараа хүргүүлсэн. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны шалгалтын ажлын хэсэг болон Дэлхийн банк, РwС аудитын байгууллагад хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн хэрэгжилтийн талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэн өгч, хамтран ажиллаж байна.</p>	<p>70</p> <p>2017 онд</p>
<p>14</p>	<p>1.2.5. Орон сууцны 8 хувийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлж, ипотекийн зээлийн даатгалыг урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний хэлбэрт шилжүүлэх</p>	<p>Ипотекийн зээлийн санхүүжилтийн схемийг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Ажлын хэсэгт Хорооны төлөөллийг оролдуулах саналыг Монголбанкинд хүргүүлээд байна. Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хог байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А-304/175 дугаар тушаалаар Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг цаашид хэрхэн үргэлжлүүлэх, банкнаас барилгын салбарт олгосон зээлийн эргэн төлөх хугацааг сунгах боломжтой эсэх асуудлыг судалж, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үндэслэн ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 2 удаа хуралдаж “Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр”-ийг боловсруулаад байна. Үүний дагуу Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 10 дугаар сарын 25 ны өдрийн А/295 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Монголбанк 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарыг хүртэл хугацаанд 8 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн эзэмшиж буй ИЗББ-ын мөнгөн урсгалаар санхүүжүүлсэн бөгөөд тус хугацаанд нийт 2924 зээлдэгчийн 187.2 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийг санхүүжүүлсэн. Харин Монголбанк ОУВС-тай тохиролцсоны дагуу 2017 оны 5 дугаар сараас хойш хөтөлбөрийг өөрийн эзэмшил дэх ИЗББ-ын үндсэн төлбөрийн мөнгөн урсгалаар санхүүжүүлж байна. Үүний хүлээнл 2017 оны 5 дугаар сараас 9 дүгээр сарыг лvvстай хугацаанд нийт 1773 зээлдэгчийн 79.7</p>

15		<p>тэрбум төгрөгийн орон сууцны зээлийг санхүүжүүлсэн.</p> <p>Орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад холбогдох ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд 1. Орон сууцны санхүүжилтийн бүтцийг өөрчлөх, 2. Хүүний буцаалтын системийг нэвтрүүлэх саналуудыг боловсруулж, дараах хурал, зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн. Үүнд:</p> <p>a. 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн орон сууцны зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийн талаарх зөвлөгөөн</p> <p>b. Мөн өдрийн захирлуудын зөвлөлийн хурал,</p> <p>c. 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Монголбанк, Сангийн ямны хоорондын уулзалт</p> <p>d. 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн СТБЗ-ийн хурал</p> <p>Монголбанк нь Засгийн газрын холбогдох яамд, Санхүүгийн зохицуулах хороотой энэ чиглэлээр бодлого чиглэлээ уялдуулах зорилгоор ажлын хэсэг байгуулан хамтран ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн орон сууцны санхүүжилтийн оновчтой бүтцийг гаргах, сайжруулах, санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрхдэлээс сэргийлэх зорилгоор Дэлхийн банкаас техник туслалцааг авч, хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд үүний хүрээнд 2017 оны 1 дүгээр сараас хойш Дэлхийн банкыг холбогдох тоо мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн Дэлхийн банкны эксперт А.Милотинг 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 14-ний өдрийн хооронд хүлээн авч Хөтөлбөрт оролцогч талуудтай уулзалт зохион байгуулж, мэдээллээр ханган хамтарч ажиллалаа.</p>	70
16	<p>1.2.6. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон төслүүдийг урт хугацааны санхүүжилтээр хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын сан байгуулах</p>	<p>Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2017 оны 3-р сарын 20-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Хөрөнгө оруулалтын сан байгуулах тухай асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх шийдвэр гарсан ба Засгийн газарт танилцуулж, Засгийн Газрын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг дэмжсэн төслүүдийг санхүүжилтээр хангах хөрөнгө оруулалтын сангууд үүсгэн байгуулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компанийг Хөгжлийн банкны охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан.</p>	40
16	<p>1.2.7. Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, экспортын даатгалын бүтээгдэхүүн бий болгох замаар экспортогч үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих</p>	<p>Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциациас “Экспортыг дэмжих төсөл”-ийн хүрээнд Экспортын даатгалын үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХХК-ийн /ХААД/ охин компани байдлаар Засгийн Газар болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд Экспортыг дэмжих төслийн санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулсан. Түүнчлэн 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр тус хэлэлцээрийг Монгол Улсын Их хурлаар соёрхон баталсан. Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2017 оны ажлын төлөвлөгөөнд Экспортын даатгалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, экспортын даатгалын үйл ажиллагааны харилцааны зохицуулалтын талаар холбогдох судалгааг энэ онд хийхээр төлөвлөн судалгааны ажлыг эхлүүлээд байна.</p>	40

17	1.3. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх тадаад өр төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх	<p>1.3.1. Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх</p> <p>“Алт-2” үндэсний хөтөлбөрийг 2017 оны 1 дүгээр сарын 18-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 20 дугаар тогтоолоор багтуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 17-р захиралгаар “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг байгуулсан.</p> <p>Тус зөвлөлийн дарга Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/42 тоот тушаалаар салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг багтаж 4 чиглээр хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулах байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг байгуулан “Алт-2” үндэсний хөтөлбөрт тусгагдсан үндсэн 5 зорилтын хүрээнд зорилгод арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>“Алт-2” үндэсний хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөг УУХҮС-ын А/66, СС-ын 202, БОАЖС-ын А/174, МБЕ-ийн А-166 тоот хамтарсан тушаалаар баталж хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1.Татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Уулын ажлын тайланд үндэслэн алт болон бусад салбарын татварын хувь хэмжээ, нийт зардал болон борлуулалтын орлогод эзэлж буй хувь хэмжээг тогтоох замаар татварын ачааллын судалгааг шинэчилж гаргасан./3.1.1/ 2.УУХҮЯ-наас “Алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, хамгаалах, хүлээлцэх, тээвэрлэх худалдахтай холбогдсон журам”-ын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловруулсан. Захиргааны ерөнхий хууль-Е4д заасны дагуу эвб сайтад байршуулан олон нийтээс санал авсан. Мөн Сангийн яам болон Стандарт хэмжил зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос албан ёсоор санал авч зарим аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн саналыг төсөлд тусгасан. АМГТГ-тай хамтран алтны чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр алтны салбарт тулгамдаад байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхөл боломжийн талаар санал солилцон шинээр боловруулсан журмын төслийг танилцуулан хэлэлцүүлэх хийсэн. Журмын төсөлд холбогдох газруудаас ирүүлсэн саналыг тусган эцэслэн боловруулж 2 сайдын хамтарсан тушаалаар багтуулахаар хүргүүлээд байна./3.1.3/ 3.Алтны салбарт олгох санхүүгийн дэмжлэг олгож байсан өмнөх сайн туршлагаудыг судлах, боломжит хэлбэрүүдийн талаар санал боловруулж байна. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн тайланг 2017 оны 9 дүгээр сард бэлтгэн ирүүлсэнтэй танилцахад Санхүүжилт шаардлагаатай алтны 130 төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банканд хүргүүлсэн. Одоогийн байдлаар Хөгжлийн банк зээллэг хүссэн 24 ААН-ийг судалж 2017 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 10 аж ахуйн нэгжид нийт 27.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бол олгохоор хүлээгдэж буй зээлийн хэмжээ 8.9 тэрбум төгрөг байна. 4.Алтны олборлолтыг дэмжих зорилгоор тусгай зориулалттай талбайн бүсийн судалгааг Заамарын, Сэлэнгийн нутаг дэвсгэрийн хүрээнд хийж хил заагийг тогтоон Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлдээд байна. Сэлэнгэ аймгаас ирүүлсэн орон нутгийн саналыг АМГТГ-г хүргүүлэн шийдвэрлэх боломжтой эсэхийг нягталж байна./3.1.7/ 5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хууль бусаар олборлолт явуулсан талбайн мэдээллийн судалгааг орон нутгаас авч нэгтгээд байна. Мөн цагдаагийн байгууллагаас холбогдох мэдээллийг авч ажиллаж байна. 2.Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулах зорилтын хүрээнд:
----	--	---

1. Алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны алтны хэтийн төлөвийг үнэлэх, алтны эрэл-үнэлгээний сэдэвчилсэн судалгааны ажлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулсан. Тус сэдэвчилсэн судалгааны ажлыг 2017 онд Монгол орны төв, зүүн бүсийн хэмжээнд гүйцэтгэхээр төсөв, төлөвлөгөө, геологийн даалгаврыг боловсруулан гүйцэтгэгч хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтын ажил хийгдэж "Geo Текс Импекс" ХХК шалгаран төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна./3.2.1/

2. Хойд Хэнтийн алтны металлогены бүсэд хамаарах Төв, Сэлэнгэ, Дархан-уул, Булган аймгуудыг хамарсан буюу Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумд, Дархан-уул аймгийн Шаран гол, Хонгор сумд Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутаг дэвсгэрийг судлан нэгдсэн зохион байгуулалт бүхий бүсийн хил заагийг тогтоон хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
/3.1.7/

Хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 37 тоот тогтоолыг багтуулсан. Хайгуулын тусгай тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг боловсруулан Засгийн газрын хэрэг-эрхлэх газарт хүргүүлсэн. 2009-2014 онд хийгдсэн 1:50000-ны масштабтай Улсын геологийн эрэл шалгалтын ажлаар тогтоогдсон илрэл эрдэсжсэн цэгүүдийн мэдээллийг үндэслэн 1.6 сая га талбайг ялан 3Г-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Хөрөнгө татах, өргөдлөөр талбай авах сонголт, боломжийг нэмэгдүүлэх үүднээс 18,2 сая га талбайг ялан 3Г-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

3. Алтны шороон ордын 17, үндсэн ордын 2 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн улсын нөөцийн санг 4393,0 кг нөөцөөр нэмэгдүүлээд байна.

100

3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх зорилтын хүрээнд: 1.Г ацууртын алтны үндсэн ордыг ашиглах хүрээнд Орд ашиглах гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээр хийх Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд Ажлын хэсгийг Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулан байгуулсан. Г ацууртын алтны үндсэн ордыг ашиглах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж, орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцэн тусгах, гэрээний төслийг бэлтгэхэд оролцон санал боловсруулсан. Дэд ажлын хэсэг нийт 4 удаа хуралдсан. Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний анхны төслүүдийг боловсруулан "Сентерра Г оулд" ХХК руу санал авахаар хүргүүлсэн. 2. Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 3-р сарын 29-ний өдрийн А/62, А-98 тоот хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий УУХУЯ, Монголбанк, Стандарт хэмжил зүйн газар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл оролцсон Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн календарчилсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Монголбанк, ARGOR-HERAEUS S.A. компанийн төлөөлөлтэй алт цэвэршүүлэх үйлдвэрийн суурь судалгааг хийлгэх асуудлаар Ажлын хэсгийн уулзалт зохион байгуулсан. Судалгааны тайланг Монголбанкны захиалгаар тус компаниар гүйцэтгүүлэхээр гэрээ хийгдэж байна. 3. 2017 оны 9 сарын сүүлийн үеийн байдлаар нийт 14,7 тн алт Монголбанкинд тушаагдаад байна. 4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгаль орчныг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны

дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтоолоог бий болгох зорилгын хүрээнд: 1. "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын түр журам"-ын төслийг боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулж удирдлагад танилцуулсан. Улмаар БОАЖСайдаас санал авахаар 05 дугаар сарын 22-ны 01/1166 албан тоогоор хүргүүлсэн. "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төсөл боловсруулах Дэд ажлын хэсгийг УУХҮЯ, БОАЖЯ, АМТГ болон судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, журмын төслийн талаар санал солилцсон. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, вэб сайтад төслийг байршуулан олон нийтийн саналыг авч байна. 2. Сэлэнгэ, Төв аймгийн нутагт алт олборлогч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нөхөн сэргээлтийн байдалд БОАЖЯ, УУХҮЯ, АМТГ, ЦЕГ, орон нутгийн мэргэжлийн хяналтын газар, тухайн орон нутгийн захиргаанаас нэгдсэн шалгалтыг хийж газар дээр нь очиж танилцан голыг бохирдуулж байгаа шалтгаан цаашид авах арга хэмжээний талаар нэгдсэн хурлыг зохион байгуулав.

3. Нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн мэдээллийг орон нутгаас урьдчилсан байдлаар гаргуулж аваад байна. Нөхөн сэргээлт хийх талбайг эзэнжүүлэх асуудалд орон нутагтай санал солилцон ажиллаж байна. БОАЖЯ-с санаачлан эндэрсэн, эзэнгүй орхигдсон талбай болон нөхөн сэргээх шаардлагатай газрын судалгааг 2017-2018 онд хийж дуусгах аар хамтран ажиллаж байна.

5. Бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгын хүрээнд:

1. "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслүүдийг боловсруулан, 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, дээрх 2 журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна./3,5,4/

2. Бичил уурхай эрхлэх талбайн судалгааг аймгуудаас хүлээж аван саналыг нэгтгэн холбогдох байгууллагаар хянуулан бичил уурхай эрхлэх боломжтой 6 аймгийн нутаг дэвсгэрт нийт 18 талбайг ялгаад байна.

3. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор батлуулсан.

<p>1.3.2. Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх, дахин санхүүжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<p>Монгол улсын Засгийн газар Хөгжлийн банкны 580 сая ам.долларын Евробондыг Засгийн газрын 7 жилийн хугацаатай, 8.75 хувийн хүүтэй Хуралдай бондоор солих саналыг бондын эзэмшигчдэд тавьсан ба 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдөр нийт 476 сая ам.долларын бонд эзэмшигчид буюу 82.07 хувь нь энэхүү саналыг хүлээж авснаар хэлцэл амжилттай болсон. Дээрх хэлцэлтэй залуулан Хөгжлийн банкны бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгийг төлөх зорилгоор 124 сая ам.долларын Хуралдай бондыг нэмж арилжаалахаар зарласан ба гадаадын хөрөнгө оруулагчид уг бондыг авахаар нийт 3.3 тэрбум ам.доллар буюу 27 дахин илүү дүнгтэй санал ирүүлж, эцсийн дүнгээр 124 сая ам.долларын бондыг 7.625 хувийн зах зээлийн өгөөжтэйгөөр арилжаалсан. Хөгжлийн банкны евробондыг хугацаанд амжилттай төлж дуусгасан. Өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн хэрэгжилтийг Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу 2016 оны Төсвийн гүйцэтгэлийн хамт стратегийн баримт бичгийн явцын тайланг Засгийн газарт оруулж тайлагнахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын өрийн удирдлагын баримт бичгийн баримт бичгийн баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж, 4 дүгээр сард Яамны удирдлагуудад танилцуулсан. Тус стратегийн баримт бичигт болдогын 5-н зорилт, тэдгээрт нийцүүлэн 4-н тоон шалгуур үзүүлэлтийг дэвшүүлсэн.</p>	100
<p>1.3.3. Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкны болзошгүй өр төлбөрийг судалж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах</p>	<p>Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017.01.17-ны өдрийн 14/А-19 тоог хамтарсан тушаалаар "Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөний төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулж гадаад өрийн үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай валютын эх үүсвэр, дотоод зах зээл дэх нөөц бололцоог судлах, өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн төслийг бэлтгэх зэрэг ажлыг авч хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах, батлуулах шийдвэр гарсны дагуу Засгийн газрын өрийн багцын өнөөгийн болон ирээдүйн боломжит эх үүсвэр, хэрэгтээ шаардлагыг судалж, Засгийн газрын өрийн удирдлагын 2018-2020 оны стратегийн баримт бичгийн төслийг боловсруулаад байна. Засгийн Газар, Монголбанк, Хөгжлийн банкны болзошгүй өр төлбөрийг судалж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах ажлын хүрээнд: - Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсантай холбоотойгоор Хөгжлийн банкны ОУ-ын банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн Засгийн газрын баталгаатай болон баталгаагүй эх үүсвэрүүд хугацаанаасаа өмнө буцаан дуудагдах эрсдэл үүссэн. Ингэснээр Хөгжлийн банкны ОУ-ын банк ОУХОБ, ВЭБ банкуудад (Засгийн газрын баталгаатай болон баталгаагүй эх үүсвэрүүд хугацаанаасаа үлдэгдлийг буцаан дуудуулахгүй байхаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа ба эрсдэлтэй шатандаа явагдаж байна. Үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах үүднээс "Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөө"-г боловсруулж байгаа бөгөөд тус төлөвлөгөөний зорилго нь Хөгжлийн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад холбогдох үзүүлэлтийг хангахад чиглэсэн байна. 2017 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөгжлийн банкны тухай хуулийн хэлэлцүүлгийн шатанд тус банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, активын ангилал, эрсдэлийн сан байгуулах зарлуулах журмыг Монголбанкнаас баталсан</p>	70

<p>1.3.4. Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах ажлын хүрээнд дараах нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах</p>	<p>Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах ажлын хүрээнд дараах нэн хөнгөлөлттэй зээлийн гэрээ, хэлэлцээрийг байгуулж УИХ-аар соёрхон батлуулав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импортын банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр. 2. Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын 79 сая ам.долларын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр. 3. Монгол Улс, Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын 50 сая еврогийн ерөнхий хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлуулав. 4. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1.0 тэрбум ам.долларын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлт. 5. Монгол Улсын Засгийн газар, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангай хамтран хэрэгжүүлэх “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 9.08 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр” зэрэг болно. <p>Монголбанк, Хятадын ардын банк хооронд 2014 онд байгуулсан Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хугацааг сунгах, хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2017.02.23-нд ХАБ-ны Дэд Ерөнхийлөгч Ий Ганг-тай хэлэлцээр хийж гэрээг дахин 3 жилийн хугацаатай сунгах тохиролцоонд хүрсэн. Шинэчлэн сунгах своп хэлцлийн гэрээний төсөлд хоёр Төв банкны ажилчдын түвшинд эгэслэн тохиролцсон.</p>	70
<p>1.3.5. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны А-35/33/64 дүгээр хамтарсан тушаалаар "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн төслийг боловруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж хөтөлбөрийн Засгийн газраар батлуулсан. Энэ хүрээнд "Хөрөнгийн зах зээл" дэд ажлын хэсэг байгуулагдаж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчны үнэлгээг хийсэн бөгөөд IOSCO үнэлгээний аргачлалын дагуу дээрх 3 байгууллага үнэлгээг гүйцэтгэж, харилцан хянасан. Холбогдох саналыг гаргаж, дэд ажлын хэсгийн хүрээнд нэгтгэж, үндсэн ажлын хэсэгт тайлагнасан болно. Арилжааны шимтгэлийг бууруулах, данс нээгдэхэд тавилдах шаардлагуудыг хөнгөвчилж, хялбаршуулсан зохицуулалтыг бий болгох, харилцагч үйлчлүүлэгчдэд ойлгомжтой болгох зорилгоор дүрэм, журмуудын уялдаа холбоо, давхардал, хийдлийг судлах ажил эхэлсэн. Дэлхийн банкны "Олон Салбарыг Хамарсан Техник Туслалцааны Төсөл"-ийн зөвлөх багтай хамтран мэргэжлийн оролцогчдын дунд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулсан. "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулаад байна. Хөтөлбөрт санхүүгийн салбарт авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 22 зорилго, 53 зорилт, 120 арга хэмжээг тусгасан.</p>	70

2017-2018 оны
эхний хагас
жилд

22	1.3.6. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж ажиллах	<p>Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн эрх зүйн үндэслэлийг баталгаажуулсан, тогтоол шийдвэр гаргах ажлын хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн батлах тухай” 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 10 дугаар тогтоолын 2 дах заалт “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг” ЗГХЭГ-ын даргын дэргэд ажиллуулж, Ажлын албаны чиг үүргийг тус газрын Хууль, эрх зүйн газарт харилцуулахаар шийдвэрлэсэн. Мөн ЗГХЭГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 353 дугаар тушаалаар “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан. Монгол Улсын Ерөнхий сайдын “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 136 дугаар захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдан ажиллаж байна.</p> <p>ҮХГ-аас Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн гишүүний хувьд хийж гүйцэтгэсэн ажил үүрэг: -2017 оны 3 дугаар сарын 16-нд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн анхны хуралдаан зохион байгуулагдсан бөгөөд хуралдаанд ҮХГ-ын дарга Г.адаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын гэрээний үйл явц, хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулж буй байдалын талаар мэдээлэл хийсэн. Анхны хуралдааны үүрэг даалгаврын хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 12-ны Хууль зүй дотоод эргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ҮХГ-ын даргын хамтарсан ХЗДХЯ-ны А-33, ҮХГ-ын А-49 дугаар тушаалаар Хөрөнгө оруулагчдын эрх зүйн орчныг сайжруулах хамтарсан ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулагдснаас хойш дараах гомдлуудыг шийдвэрлээд байна. Тус зөвлөлд ирсэн “Мобиком нэгворкс” ХХК-ийн гомдлыг шийдвэрлэж Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн №01 дугаартай зөвлөмжийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p>	100
23	1.3.7. Банк, санхүүгийн системийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, гадаадын банкны салбар нэгж нээн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	<p>Дотоодын санхүүгийн зах зээлийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, аливаа нэг гадаад банкинд давамгай байдал үүсгэхгүй байх, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд гадаадын банкны актив хөрөнгө, тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтын чиглэлээр Банкны тухай хуулийн 22.2-т заасны дагуу холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Банкны зөвшөөрлийн журмыг шинэчлэх ажлын хүрээнд гадаадын банкны охин компанийг Монгол Улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг дэлгэрэнгүй тусгасан болно. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар гадаадын банкууд манай улсад үйл ажиллагаа явуулахад хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, санхүү болон үндэсний аюулгүй байдлын хүрээнд судалгаа хийхээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, санал, дүгнэлт боловсруулсан.</p>	40
24	1.3.8. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;	<p>Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах Улсын комисс 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр үйлдвэр дээр ажиллан, үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулаад байна. Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт орших Хар Овоогийн холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч “Дун юань” ХХК-ийн удирдлагатай УУХУ-ийн яамны төлөөлөл уулзалт зохион байгуулж, тус төслийн өнөөгийн байдал, явцын талаар танилцан, тулгамдсан асуудлаар зөвлөдөл. /Тус уулзалтаар “Дун юань” ХХК-ийн удирдлагад Хар-Овоогийн холимог металлын ордыг ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, уулын ажлын төлөвлөгөө зэргийг холбогдох хурлуудаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг даалгав./ БОАЖЯ-наас томилогдсон ажлын хэсэгт УУХУЯ-ны төлөөлөл ажиллаж байна. Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Ширэн Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эзст Өндөр” ХХК-ийн удирдлагатай УУХУЯ-ны төлөөлөл уулзалт зохион байгуулж, тус төслийн өнөөгийн байдал, явцтай танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөдөл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төслийг цаашид явуулахад Сүмбэрийн боомтын зохицуулалтыг үйл үйлдлийн бүтээгдэхүүн ашиглахад зохицуулалттай болгох боомтын ажиллах хуваарийг компанийн үйл</p>	

ажиллагаатай уялдуулан ажилладаг болгон өөрчлөх саналыг өгөөд байна. "Зэст Өндөр" ХХК одоогийн байдлаар төслийн үйл ажиллагаанд нийт 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байгаа ба Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийг байгуулан туршилтын үйлдвэрлэл явуулан 2000 тн баяжмал үйлдвэрлээд байна. / Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Дулаан хар уулын холимог металлын дагд уурхай, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "Юмингшин" ХХК - нь санхүүгийн хүндрэлтэй байдалд орсон шалтгаанаар үйл ажиллагаагаа зогсоогоод байна/ Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт орших Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эм Эл Цахиурт Овоо" ХХК-ийн удирдлагагай уулзалт зохион байгуулж, тус төслийн өнөөгийн байдал, явцын талаар танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөлдөв.

Цагаан суваргын ээс-молибдений ордын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлын явц 46.1 хувьтай бөгөөд цаашид төслийн бүрэн хүчин чадлаар ашиглалтанд оруулахад 600.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагагай байна. Мөн төслийн хүрээнд тус ордын исэлдсэн хүдрийг түшиглэсэн катодын эсийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах шинжээчийн хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаалаар байгуулсан. Ордын бүтээн байгуулалтад Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт бүрэн хийгдсэн бөгөөд төслийн талбайд утсрагдан олборлолтонд бэлэн болсон. Тонног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулснаар үйлдвэрийг 2018 оны 2 дугаар хагаст ашиглалтад оруулах боломжтой болно.

Газрын тосны гэрээлэгч компаниудаас 2017 онд Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян Цагаан-Элсний орлод одоогийн байдлаар нийт 794 олборлолтын цооног ашиглаж байгаа ба "Орд ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн дагуу ашиглалтын хугацаанд дээрх ордуудад нийт 2184 олборлолтын цооног ашиглахаар төлөвлөсөн.

Уг хөтөлбөрийн хүрээнд газрын тосны орд ашиглалтыг эрчимжүүлэх зорилгоор 2017 онд 7000 метрт перфораци хийх, 166 цооногийн 366 үед шингэн хагалбар хийх, 78 цооног ус шахалтанд шилжүүлэх, 21 цооног их засвар хийх, ашигт давхаргын 10 үеийг хүчлээр угаах, 147 цооног өрөмдөх, шинээр 159 цооног ашиглалтанд шилжүүлэх, 115000 тонн тос шавхалтын аргаар олборлох ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Эдгээр төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэсэнээр олборлолт өмнөх оноос 2 хувиар нэмэгдэж, 8.1 сая баррель буюу 1.1 сая тоннд хүрнэ.

Гэрээлэгч компаниудаас 2017 онд Тосон-Уул XIX талбайд 210.0 сая ам.доллар, Тамсаг XXI талбайд 231.0 сая ам.доллар, БХГ-97 талбайд 11.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийж, 1.1 сая тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 233.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 760 мянган тонн газрын тос экспортолж 126.4 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулаад байгаа ба экспорт 66.4%, төсвийн орлого 54.2%-ийн гүйцэтгэлтэй байна.

Газрын тосны нарийн мэргэжлийн ажил гүйцэтгэх гадаадын инженер, техникийн ажилтнуудын талаар мэдээллийг судалж, нягтлан, тэдгээрт Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 823 хүнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлүүлсэн.

Дорнод аймагт малын гоц халдварт өвчин гарч газрын тосны тээвэрлэлтийг 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 3 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл, Дорнод аймгийн Засаг даргын А/425 дугаар захирамжаар газрын тосны тээвэрлэлтийг 9 дүгээр сарын 22-ноос 29-ний өмнүүлэл зогсоосон нь олборлолт төвлөрүүлэлтийн үйл ажиллагаанд нөлөөлсөн.

Чойбалсангийн ДЦС-аас Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад нийлүүлж байгаа эрчим хүчний хэмжээ нь олборлолтыг нэмэгдүүлэх, ордуудын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд нөлөөлж байна.

БНЭУ-аас олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Газрын тос боловруулах үйлдвэр" байгуулах төслийг санхүүжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Сангийн яамтай хамтран Засгийн газрын хуралдаанд танилцуулж Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр тус төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх боломжтой болсон. Мөн төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловруулах, БНЭУ-ын Эксім Банкны шаардлага хангасан Зөвлөх компаниудаас сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хураангуй жагсаалтад багтсан Энэтхэгийн компаниудад хүргүүлж, саналыг аваад байна. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн урьдчилгаа төлбөр болон тендер зохион байгуулахад 300.0 сая орчим төгрөг шаардагдаж байна. Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Төрийн өмчиг компани байгуулах тухай" 92 дугаар тогтоолоор БНЭУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловруулах үйлдвэр барих" төслийн хүрээнд 100 хувь, Төрийн өмчиг компани байгуулагдаад байна.

1. Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 92 дугаар тогтоолоор төсөл хэрэгжүүлэх "Монгол газрын тос боловруулах үйлдвэр" ТӨХХК байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд 2016 онд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зориулалтыг өөрчлөх асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлэн, УИХ-ын чуулганы 5 сарын 31-ний өдрийн хуралдаанаар зээлийн хэлэлцээрийг соёрхон батлуулсан.

2. Нарийвчилсан ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт тавих компани сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер явуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 7-р сарын 5-ны өдрийн А/113 тоот тушаалаар байгуулсан.

3. Хөндлөнгийн хяналт тавих компани сонгон шалгаруулах нээлттэй тендерт оролцох хүсэлт илэрхийлэх зарыг 7-р сарын 6-нд монгол болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэлсэн. Улмаар нийт 7 компани /АНУ, Итали, Англи, Саудын Араб, Энэтхэг, Сингапур улсууд/ оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд Үнэлгээний хорооноос хураангуй жагсаалтад орох компанийг сонгох үнэлгээний ажлыг хийж дуусгаад байна.

4. Газрын тос боловруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-г хийж гүйцэтгэх компанийг сонгох сонгон шалгаруулалтад Энэтхэг улсын 4 компани оролцож, элгээрээ Мекон лимитед, Инженерс Индия лимитед хураангуй жагсаалтад багтаж улмаар Энэтхэг улсын төрийн өмчиг компани Инженерс Индия лимитед шалгарч Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг УУХҮЯ, Монгол газрын тос ТӨХХК-тай 8-р сарын 9-нд байгуулсан.

Монгол улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 114 дүгээр захирамжийн дагуу Зэсийн баяжмал боловруулах арга хэмжээний хүрээнд ажлын хэсэг байгуулагдсан. Засгийн газрын 88 дугаар тогтоолын тэмдэглэлд үүрэг болгосны дагуу Оюутолгойн баяжуулах үйлдвэр, Тавантолгойн нүүрс угаах үйлдвэр, Тавантолгойн Цахилгаан станц, Зэсийн баяжмал-25л боловруулах үйлдвэрийн усан хангамжийн асуудлаар БОАЖЯ-тай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг үндэслэн Засгийн газрын тогтоолын төслийг боловруулж 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн "Хэрлэн гол дээр урсгачтай зохион байгуулах хийх төслийн тухай" тогтоол гарч, төслийн ТЭЗҮ, БОННУ хийх ажлыг шуурхай зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Хэрлэн голын урсгачтай зохион байгуулга хийх төслийн ТЭЗҮ хийхэл шаардлага хөрөнгийг 2018 оны төсвийн төсөлд тусгвчлуулахаар БОАЖЯ-наас Сангийн яаманд

саналаа ирүүлээд байна. Эссийн баяжмал боловруулах үйлдвэрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд 30-аад компанид хандсанаас 10-аад компани саналаа ирүүлээд байна. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг хийх Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх дотоодын компаниг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. Төсөл хэрэгжүүлэгч нь сонгосон байрлалд, техникийн нөхцөлүүд болон шаардлагатай зөвшөөрлүүдийг авна.

Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 91 дүгээр тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах "Эссийн баяжмал боловруулах үйлдвэр"-ийн ойролцоо ирээдүйд байгуулагдах "Эссийн баяжмал боловруулах үйлдвэр"-ийн салбар төмөр замыг "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замаас салаалах техникийн нөхцөлийн боломжийг судлан, дүгнэлт гаргахаар үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Нүүрснээс нийлэгт байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх мөн тус төслийн "Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ"-ний ажлыг гүйцэтгэх олон улсын нээлттэй тендэрт "БНХАУ-ын "Wuhan Engineering Co., Ltd" компани, туслан гүйцэтгэгчээр "Гранд Повер" компани "Грийн трендс" компаниуд шалгарч 2016 оны 03 дугаар сард гурвалсан гэрээг байгуулсан. Гэрээний дагуу "Wuhan Engineering" компаниас 2017 оны 01 дүгээр сард "Байгалийн хийн зах зээл, үйлдвэрийн хүчин чадлын судалгаа", "Нүүрсний уурхайн сонголтын тайлан", "Усны нөөцийн судалгааны тайлан", "Шугам хоолойн трассын сонголтын урьдчилсан тайлан", "Тусгай судалгааны тайлан", "Нүүрс хийжүүлэх технологийн харьцуулсан судалгаа", "Метанжуулах технологийн харьцуулсан судалгаа"-ны тайлангуудыг хүлээн авсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар тусгай судалгааг үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сарын 5-нд хүлээн аваад байна. "Бүс нутгийн байгаль, орчны үнэлгээний урьдчилсан тайлан"-г ирүүлсэн ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайланг гэрээний дагуу БОННУ болон "Бүс нутгийн байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг 2017 оны 8-р сарын 24-нд хүлээн авсан.

25	1.3.9. Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 10 дугаар тогтоолын 2 дахь заалт "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг" ЗГХЭГ-ын даргын дэргэд ажилдуулж, Ажлын албаны чиг үүргийг тус газрын Хууль, эрх зүйн газарт хариуцуулахаар шийдвэрлэсэн. Мөн ЗГХЭГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 353 дугаар тушаалаар "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан. Төрийн бус байгууллагуудын оролцоотой мэргэшлийн зөвлөл байгуулахаар төлөвлөж, мэргэшлийн зөвлөлийн хүрээнд хийгдвэл зохих ажлын төлөвлөгөөг гаргаж ажиллаж байна. Японы хамтын ажиллагааны байгууллага /JICA/-аас хэрэгжүүлж буй "Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн багтай хамтран дотоодын ҮИЦ-уудын үйл ажиллагааг сайжруулах, гэдгээрийн харилцагчдад учирсан хохирлыг барагдуулах тогтоолоог бүрдүүлж хүрээнд "Хөрөнгө оруулагчийн хамгаалах сан" сэдэвт семинарыг зохион байгуулав. Олон Улсын санхүүгийн корпорациас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлээд байна. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэг цаасны газраас Япон, Америк улсуудын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаарх эрх зүйн орчныг судалж байна	40
26	2.1. Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх Үндэс суурийг тавих	Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 59 дүгээр тушаалаар байгуулагдсан Монгол Улс БНХАУ-тай агаарын хаалга шинээр нээх, агаарын зайн ашиглалтыг сайжруулах замаар олон улсын өнгөрөлтийн нислэгийг нэмэгдүүлж, навигацгийн үйлчилгээний орлогыг өсгөх, эдийн засгийн үр ашгийг сайжруулах арга замыг судлах ажлын хэсгийн хуралдаанаас бэлтгэл ажлыг хангаж ажиллах дэд ажлын хэсгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/753 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх, агаарын навигацгийн хураамжийн аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр IATA-ын гишүүн агаарын тээвэрлэгчидтэй зөвлөлдөх уулзалтаар Монгол Улсын агаарын навигацгийн хураамжийг тогтоох шинэчилсэн аргачлалын талаар танилцуулсан бөгөөд уг аргачлалыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. Мөн түүнчлэн олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн "Агаарын замуудыг шинэчлэн тогтоох тухай" 09 дүгээр тушаалаар Монгол Улсын агаарын зайд үзүүлэлтэд тулгуурласан навигац бүхий замуудыг шинэчлэн тогтоож 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна. Энэ 2017 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар олон улсын өнгөрөлтийн 82,205 нислэг, олон улсын хөөрөлт буултын 6,023 нислэг, орон нутгийн хөөрөлт буултын 4,508 нислэг гүйцэтгэгдсэн байна. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийнхтэй (73,648) харьцуулахад 8,557 нислэгээр буюу 11.6 хувиар, олон улсын буулт хөөрөлтийн нислэгийг өмнөх оныхтой (5,170) харьцуулбал 16.5 хувиар, орон нутгийн буулт хөөрөлтийн нислэгийг өмнөх оныхтой (3,822) харьцуулбал 17.9 хувиар тус тус өссөн байна.	70
27	2.1.2. Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх, хил орчмын төрийн байгууллага хоорондын уялдааг хангаж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, Үйлчилгээг сайжруулах	Москва хотноо 2016 оны 11 дүгээр сарын 1-2-ны өдрүүдэд болсон Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны Ажлын хэсгийн II хуралдааны үеэр Монголын тал тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах зорилгоор Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ач холбогдлыг судлах Хамгарсан судалгааны ажлыг эхлүүлэх тухай саналыг дэвшүүлсэн. Уг асуудлыг 2017 оны 2 дугаар сард тус комиссын Хуралдааны зөвлөлдөх хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрийн талаар Монголын талд мэдэгдэхээр тохиров. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Евразийн эдийн засгийн комиссын Интеграцитай, макро эдийн засгийн асуудал эрхэлсэн сайд Т.Д.Валова нар 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр "Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комиссын хамтын ажиллагааны ажлын хэсгийн 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд гарын үсэг зурав. Уг төлөвлөгөөнд худалдаа, зам тээвэр, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн салбар хооронд хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, туршлага солилцох, дугуй ширээний уулзалт, сургалт, семинар зохион байгуулах зэрэг ажлыг тусгасан болно. Түүнчлэн төлөөлөгчид Монголын нийт 50 гаруй компанийн 100 гаруй бизнес эрхлэгчидтэй уулзалт хийж, санал солилцов. Гадаад харилцааны сайд П.Мөнх-Оргилын үйлчлэлээр ФАЭК-ын Техникийн зохицуулагчдын асуудал эрхэлсэн сайд В.Н.Комешков тэргүүтэй төлөөлөгчид	

2017 оны 3 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийв. Төлөөлөгчид Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхэд бараалхаж, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, МҮХАҮТ-ийн дарга М.Оюунчимэг, СХЗГ-ын дарга Г.Гантөмөр, МХЕГ-ийн дэд дарга Г.Сугарбат нартай тус тус уулзаж, цаашид Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хоорондын стандарт, техникийн зохицуулалт, мал эмнэлэг, ургамлын эрүүл ахуйн чиглэлээр хамтран ажиллах тухай Санамж бичгийг байгуулахаар тохиролцов. Үүнтэй холбогдуулан ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, СХЗГ-ын дарга Г.Гантөмөр, МХЕГ-ын дэд дарга Г.Сугарбат нар ЕАЭК-ын сайд В.Н.Корешковтой хийсэн уулзалтын үеэр хамтран ажиллах тухай санамж бичгийн төслийг тус тус гардуулсан. ЕАЭК-оос “Стандарт, хэмжил зүйн газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын техникийн зохицуулалт, итгэмжлэлийн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”, “МХЕГ болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын мал эмнэлэг, ургамлын хорио пээрийн хяналтын салбарт хамтран ажиллах тухай Санамж бичиг”, мөн “Мал эмнэлэг, ургамлын эрүүл ахуй, техникийн зохицуулалтын салбарт хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулан, харилцан тохиролцож, гарын үсэг зурахац бэлтгээд байна. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, “Мах маркет” зэрэг мах боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж, Монголын бизнесийн 110 гаруй төлөөлөлтэй уулзаж, Евразийн эдийн засгийн холбооны зах зээлд бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхэд аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй бэрхшээл, боломжууд, хэрхэн хамтран ажиллах тухай асуудлаар ярилцав. Түүнчлэн гуравдагч орноос тус Холбооны гишүүн орнуудад бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөл, шаардлага, стандарт, норм, нормативын баримт бичиг, техникийн зохицуулалтын тогтолцооны талаар 2 өдрийн семинарыг зохион байгуулав. Уг семинарт ГХЯ, ХХААХҮЯ, МЭҮГ, МХЕГ, СХЗГ, НМХГ, Хилийн мэргэжлийн хяналтын алба, МҮХАҮТ-ийн төлөөлөл болох нийт 70 орчим мэргэжилтэн, ажилтан, шинжээчид оролцов.

БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас ирүүлсэн “Замын-Үүд – Эрээний хил дамнанас чөлөөт бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг ГХЯ-ны саналын хамт 2016 оны 10 дугаар сард Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Шадар сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилтэй уулзаж, тус чөлөөт бүсийг байгуулах асуудлын талаар танилцуулга хийв. Үүний хүрээнд БНХАУ, БНКаЗУ хооронд байгуулагдсан Хоргосийн чөлөөт бүсийг судлах, бусад улстай чөлөөт бүс байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийг судлах ажлыг гүйцэтгэж байна.Эдийн засгийн коридорын “Хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төв”-ийг байгуулах эрх зүйн үндэслэлийг судалж, санал боловсруулж, ОХУ, БНХАУ-ын талтай яриа хэлэлцээ хийж дүгнэлт гаргах, шаардлагаатай баримт бичгийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гадаад харилцааны сайдын тушаалаар байгуулсан.

Ажлын хэсгийн дарга ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэн, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч Ян Чиндун, /2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр/, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд И.К.Азизов /2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр/ нартай тус тус уулзсан.

Мөн “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийн талаар санал солилцох уулзалтыг Зам, тээврийн хөгжлийн яам болон Сангийн яамны төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан. Гурван талын шинжээчдийн түвшний уулзалт 3-р сарын 24-ний өдөр Бээжин хотноо болсон. Уулзалтаар талууд Хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах Санамж бичгийн төсөл боловсруулахаар тохиролцож, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдээ хэлэлцсэн.

“Эдийн засгийн коридор” байгуулах Монгол Улсын Үндэсний ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 103 тоот тушаалаар ГХЯ-ны Дэд сайдаар ахлуулан байгуулсан.

28	2.1.3. Аялал жуулчлалын гол маршрутын зам дагуу түр буудаллах нэг, үйлчилгээний цогцолбор байгуулах	2016 онд гол маршрутын зам дагуу түр буудаллах цогцолборыг байгуулах стандартыг баталсан. Уг стандартын дагуу ЗТХЯ-аас авто замын дагуу үйлчилгээний цогцолборын А ангиллын ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд В, С ангиллын цогцолборын ТЭЗҮ, зураг төслийг холбогдох стандартад нийцүүлэн боловсруулах ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үнэлгээний хороог БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/199 дугаар тушаалаар байгуулж, ТЭЗҮ гүйцэтгэх ажлын даалгаврыг боловсруулан ТНБД-аар баглуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, ТЭЗҮ боловсруулах ажлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж байна. Элсэн тасархайн орчмын аялал жуулчлалын бүсэд эко ариун цэврийн газар байгуулахаар хувийн хэвшил ажиллаж байна.	40
29	2.1.4. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос тус хуулийг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн гишүүдийн бүрэлдэхүүн 2017 оны 05 дугаар сарын 20-26-ны өдрүүдэд БНСУ, Сингапур улсуудад ажиллаж Казиногийн үйл ажиллагаа, түүнийг хууль эрхзүйн орчин, зохион байгуулалт зэргийг судлах ажлыг зохион байгуулаад байна. УИХ-аас хуулийн төслийг эхний хэлэлцүүлгээр дэмжээд Хууль зүйн байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдсан. Энэ намрын чуулганаар батлагдахаар төлөвлөгдөн ажиллаж байна.	70
30	2.1.5. Хурдан моринь бооцоот уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Хурдан моринь бооцоот уралдааны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар тогтоолоор байгуулагдсан Аялал жуулчлалын хөгжлийн төв дээрх хуулийн төслийг боловсруулах ажлыг гэрээний дагуу гүйцэтгэж байна. Хуулийн төслийг олон улсын ижил төстэй хуулиудыг судалсны үндсэн дээр боловсруулаад байгаа бөгөөд, олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.	70
31	2.1.6. Импортыг орлох барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг боллогоор дэмжих	Барилгын материалын үйлдвэрлэлийн ТЭЗҮ-ийг 2013 онд Уу Яамны АМГ-ын эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулсан бөгөөд тодотгох ажлыг гүйцэтгэж байна. Одоогоор Баруун бүсийн цементийн үйлдвэрийг хөгжүүлэх, Барилгын дулаан тусгаарлах материалын үйлдвэрийн судалгааны ажлыг нарийвчлан тодотгоод байна. Барилгын гол нэрийн импортын бүтээгдэхүүн цементийн үйлдвэрүүдийг төрийн боллогоор дэмжиж хөнгөлөлттэй зээлд хамруулж ажилласнаар барилгын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө тодорхой хэмжээнд нэмэгдэж байна. "МАК" ХХК-ийн "Хөх Цав" цемент шохойн үйлдвэр нь жилд 1.0 сая тонн клинкер, 1 сая 70 мянган тонн цемент, 132 мянган тонн шохой үйлдвэрлэх хүчин чадал бүхий хуурай аргын бүрэн автоматжуулсан үйлдвэр ашиглагтад орсон. Мөн Монполимет групп нь Дорноговь аймгийн Өргөн суманд орших Сэнжит Худгийн шохойн чулууны орд газрыг түшиглэн Европын хамгийн орчин үеийн ЭКО технологид суурилсан 1.0 сая тоннны хүчин чадалтай үйлдвэр байгуулсан бөгөөд бүтээгдэхүүнээ зах зээлд ойртуулж, тээвэрлэлийн цаг хугацааг хэмнэх зорилгоор Улаанбаатар хотод цагт 120 тонн чадалтай клинкер боловсруулах үйлдвэрээ ашиглагтад оруулсан. Барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдаглыг бууруулах, галд	

32	2.1.7. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх	<p>тэсвэрлэлийг сайжруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй барилгын дулаалгын материалын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжиж хөнгөлөлтэй зээлд хамруулах хүсэлтийг салбарын яамнаас Хөгжлийн банкнд хүргүүлээд байна. Манай улс эрс тэс уур амьсгалтай тул барилгад дулаан алдагдлыг багасгах материал хэрэглэх шаардлагатай юм. Иймд дотоодын түүхий эдийг ашигласан хямд өртөгтэй үйлдвэрийг байгуулах аж ахуй нэгжийг бодлогоор дэмжин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар улс орны эдийн засагтай холбоотойгоор бодлогоор дэмжин ажиллаж байгаа үйлдвэрүүд зээлд хамрагдаж чадаагүй байна.</p> <p>БҮК-1 төслийн урсгал барилга нь барилгын үйлдвэрлэлийг хүйтний улирлын эрхшээлээс гаргаж, барилгын үйлдвэрлэлийн байнгын тасралтгүй ажиллагааг дэмжиж, байгаль орчинд ээлтэй, хөрс, агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах болон олон нийтийн зориулалттай барилга байгууламжийг барихад газар хөдөлгөнд тэсвэртэй, баг бөх чанар өндөр болно. Эрэл ХХК-ний Герман Улсын EBAWE компанийн нийлүүлж байгаа тоног төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи юм.</p>	70	2017-2018 оны эхний хагас жилд
33	2.1.8. “Атрын III аян”-ыг үргэлжлүүлж, үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах	<p>Ерөнхий сайдын Япон Улсад 2017 оны 10 дугаар сард хийсэн албан ёсны айлчлалын үеэр “МДМ”ХХК Японы “Грэйсай” ХХК-тай санаамж бичиг зурж, хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Монголд нутагшуулж хамтран ажиллахаар тохиролцсон.</p> <p>Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан байгуулах хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг танилцуулах практик сургалт, хэлэлцүүлгийг “МДМ” ХХК-тай хамтран 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгаас болон Улаанбаатар хотоос сүү үйлдвэрлэгчид, фермерүүд, хоршоологчид, сүүний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл нийт 100 гаруй хүн оролцож, санал, мэдээлэл солилцов.</p> <p>- “МДМ”ХХК-ийн боловруулсан “Монголын хуурай сүү” төслийг дэмжиж, санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Хөгжлийн банкнд 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/730 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус төслийн хүрээнд эхний ээлжийн хуурай сүүний үйлдвэр Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 2017 оны 6 сарын 24-нд ашиглалтад орж, үйл ажиллагаа нь жигдэрч, хэвийн ажиллаж байна.</p> <p>- Дараачийн хуурай сүүний үйлдвэрүүдийг Хэнтий аймгийн Баянхутаг сум, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумдуудын барилгын ажил дуусаж, үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил эхэлсэн. Мөн 16-н сумдын хуурай сүүний үйлдвэрийн барилгын ажил, дэд бүтэц, трансматор суурилуулах ажил явагдаж байна.</p> <p>Гаалийн албан татвараас чөлөөлүүлэх жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалтад хуурай сүүний үйлдвэрийн холбогдох тоног төхөөрөмж, хэрэгслийг хамруулах саналыг тус ажлыг хариуцсан ажлын хэсэгт хүргүүлж, баталгаажуулсан байна.</p>	40	2017-2018 оны эхний хагас жилд
33	2.1.8. “Атрын III аян”-ыг үргэлжлүүлж, үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах	<p>Ургашын урьдчилсан балансаар 271.8 мянган тонн үр тариа, үүнээс 259.2 мянган тонн буудай, 102.3 мянган тонн төмс, 75.7 мянган тонн хүнсний ногоо, 23.6 мянган тонн тосны ургамал, 47.3 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авахаар тогтоогдоод байна.</p> <p>2017 оны 9 дүгээр сарын 08-ны байдлаар 7.4 мянган га-г ангилан хадаж, нийтдээ 13.2 мянган га-гаас 11.6 мянган тонн үр тариа, 747 га-гаас 7026 тонн төмс, 1039 га-гаас 10507 тонн хүнсний ногоо, 706 га-гаас 1.5 мянган тонн тэжээлийн ургамал, 500 га-гаас 345 тонн тосны ургамал тус тус хураан аваад байна.</p>	40	2017-2018 оны эхний хагас жилд

34	2.1.9. “Малыг эрүүлжүүлэх” хөтөлбөрийг шинэчлэн эрх зүйн орчныг бий болгох	<p>ХХААХҮ-ийн Сайдын 2016 оны А-12 дугаар тушаалаар Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, Ажлын хэсэг хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг боловсруулах чиглэлээр ажилласан. Малын генетик нөөцийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг 31-ын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж 3Г-ын 48 дугаар тэмдэглэлээр дэмжигдсэн.</p> <p>УИХ-ын нэгдсэн чуулганаар 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хэлэлцүүлж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХААБХ-ны 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 02 дугаар тогтоолоор анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. 2017 оны 06 дугаар сарын 9-нд УИХ-ын Байнгын хороодоор хэлэлцүүлэн саналыг тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлдээд байна. Тус хуулийн төслийг 2017 оны намрын чуулганаар хэлэлцэн батлуулах төлөвлөгөөтэй байна.</p> <p>ХХААХҮ-ийн Сайдын 2016 оны А-17 дугаар тушаалаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт байгуулж, хуулийн төслийг боловсруулах бөгөөд хуулийн үзэл баримтлалын төслийг 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр ХЗДХЯ-аар хянуулсан. Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын нэгдсэн чуулганаар 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хэлэлцүүлж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХААБХ-ны 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. 2017 оны 06 дугаар сарын 9-нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг хийж, Байнгын хороодоор хэлэлцүүлэн саналыг тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлдээд байна.</p> <p>“Малыг эрүүлжүүлэх” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн Сайдын 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулж хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль намрын чуулганаар батлагдахаар Малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг Засгийн газарт оруулж батлуулахаар.</p>	70
35	2.1.10. “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	<p>“Ноолуур” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг ТНБД-ын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-38 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журмын дагуу – нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг боловсруулсан. Хэлэлцүүлгийн явцад үйлдвэрлэгчдээс гарч буй хүндрэлийг үндэслэн 2 хувилбар боловсруулан сайд болон удирдлагуудад танилцуулж санал, чиглэл авсан.</p> <p>Хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлгийг 6 удаа зохион байгуулж санал авч байна. Хөтөлбөрийн төслийг 3-р улиралдаа багтаан боловсруулж 10-р сард 3Г-ын хуралдаанаар батлуулахаар төлөвлөж байна.</p>	40
36	2.1.11. Гадаадын зах зээлд экспортолох боломжтой программ хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дотоод, гадаадын мэргэжлийн холбоод, дотоодын мэдээллийн технологийн аж ахуйн нэгжүүдтэй зөвлөлдөх уулзалт, чуулганыг зохион байгуулан ажиллалаа. Монголын электрон тоног, төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-тай хамтран өндөр технологийн аж үйлдвэрийн парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, парсын үйл ажиллагаа явуулахад шаардагдах 10 газрыг Төв аймгийн Зуун мод хотод олгох ажилд дэмжлэг үзүүлэн ажилласны дээр Монгол Улсын Програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо (МОСА) ТББ, Ази номхон далайн тооцоолон болох үйлдвэрлэлийн байгуулагатай (ASOCIO) хамтран “ASOCIO 2017 Multilateral Trade Visit” олон улсын арга хэмжээг 2017 оны 6 сарын 14-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж дотоодын аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргах гадаадын харилцагч, түншлэгчээ олох эхлэлийг тавиад байна. Экспортод гаргах дотоодын техник хангамжийн бүтээгдэхүүн, шийдлийн талаар салбарын аж ахуйн нэгжүүдтэй зөвлөдөг ИТ Зон ХХК компанийн боловсруулсан “Бага оврын дата төв”, “Орчны хяналтын систем”-ийн шийдлийн танилцуулга, холбогдох мэдээллийг хүлээж аваад байна.</p>	40

37	<p>2.1.12. Иргэдийг гадаад улсад тодорхой хугацаагаар ажиллуулах арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх</p>	<p>Гадаадын ажиллах хүчийг авах хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогогтой зохицой хослуулах, ажиллах хүчний шилжих хөдөлгөөний зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаа иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэднийг эх орондоо буцаж ирэхийг дэмжих нөхцөлийг бий болгох зорилгоор “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мөргэжилтэн авах тухай хууль”-ийг шинэчлэн боловсруулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагын судалгааг гаргаж, тус судалгаанд тулгуурлан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Австрали Улсын Засгийн газар хоорондын Амралтаараа ажиллах тохиролцооны тухай айлын талын төсөлд манай тал 2016 оны 11 дүгээр сард саналаа боловсруулж, Канберра дахь ЭСЯ-аар дамжуулан өгсөн.</p> <p>Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яам хооронд “Ур чадварын дадлагажигчийн хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулах чиглэлээр санамж бичгийн төсөлд манай талаас тусгах саналыг албан ёсоор хүргүүлсэн ба саналын дагуу холбогдох уулзалтыг зохион байгуулж харилцан санал солилцоод байна.</p> <p>АНУ-ын Вашингтон хотноо 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр болсон Монгол Улсын ГХЯ, АНУ-ын Төрийн департамент хоорондын 11 дүгээр зөвлөлдөх уулзалтын үеэр тохиролцсоны дагуу АНУ-д богино хугацаагаар ажиллах хүч гаргах буюу АНУ-ын Н2 ангиллын визийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг ноог бичгээр Вашингтон дахь ЭСЯ-аар дамжуулан 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр тавив. Мөн өдөр Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-ны Консулын хэлтсийн даргад ноог бичгийн хувийг гардуулсан бөгөөд АНУ-ын талаас шийдвэрээ эцэслэн гаргаагүй байна.</p>
38	<p>2.1.13. Иргэдийг шинэ ургачдын хүнсний ногоогоор хангах зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах</p>	<p>5 га талбай бүхий өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах төслийг боловсруулж төслийг Турк, БНСУ-ын Засгийн газрын зээлээр санхүүжүүлэхээр Үндэсний хөгжлийн газар, Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн төслийг Хөгжлийн банкинд хүргүүлээд байна.</p> <p>2017 оны улсын төсвийн тодотгол санхүүжилтээр 6.6 га талбай бүхий зуны нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг зарлаж нийт 720 ширхэг хүлэмжийг 4 жилийн хугацаатайгаар аймаг, нийслэлийн ногоочидлод олгосон. Нийт өртөг нь 1.9 тэрбум төгрөг бөгөөд одоогийн хүлэмжийн ногооны 5400 тонн хэмжээ 1000 гаран тоннор нэмэгдэх боломжтой болно. Түүнчлэн, орон нутагт хүлэмжийн таримлын нэр төрөл, үйлдвэрлэл нэмэгдэж 800 ажлын байр бий болно.</p>
39	<p>2.1.14. Олон улсын байгууллагаас гаргадаг зээлжих зэрэглэл, бизнес эрхлэлт, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг татах чадвар зэрэг индексүүдийг сайжруулах</p>	<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дэргэд “Улсын зээлжих зэрэглэлийг ахиулан тогтооход шаардлагатай арга хэмжээг авах” чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Фигч агентлаг нь 2017 оны 2 сарын 21-ний өдөр Улсын зээлжих зэрэглэл болон Монгол Улсын шинээр зарласан бондыг “В-, тогтвортой” хэвээр үлдээсэн бол Мүүдид агентлаг нь 2017 оны 2 сарын 15-ны өдөр Улсын зээлжих зэрэглэлийг “Саа1, тогтвортой” байсныг “Саа1, бууруулах эсхийг дахин авч үзэх” болгон өөрчиллөө. Харин Стандарт энд Пүүрс агентлаг нь 2016 оны 8 сард тогтоосон В-, тогтвортой зэрэглэлийг 2017 оны 8 сар хүртэл хэвээр хадгалах төлөвтэй байгаа тухай 2017 оны 2 сард мэдэгдэж байсан. Мүүдид агентлагийн хувьд Зэрэглэлийг бууруулах эсэх шийдвэрийг 3 сарын дотор буюу 5 сарын 15-наас өмнө гаргахдаа ОУВС-тай хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 1. богино хугацаанд эрсдэлийг бууруулах, 2. дунд хугацаанд эдийн засаг, төсөв санхүүгийн байдлыг сайжруулах, дэмжих эсэх, 3. ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд авах хоёр болон олон тагт түншүүдээс авах санхүүгийн эх үүсвэрүүд, 4. Засгийн газрын үнэг цаас хөрвөх чадвар, Монгол Улсын эрсдэл хүлээх чадварыг богино хугацаанд хэрхэн сайжруулах, дунд хугацаанд хэрхэн эерэг нөлөө үзүүлэхийг ашиглан зээлжих зэрэглэлийг тооцох тухайгаа мэдэгдэл байсан 2017 оны 5 сарын байдлаар Монгол Улсын зээлжих зэрэглэл С элл Пи (Pi-) Мvлвлиц (Саа1) Фигч (Pi-) байсан.</p>

40	<p>2.2. Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх</p>	<p>2.2.1. Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВт-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВт-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар “Таван толгойн орд газрыг лэд бүтцийн хамт иж бүрнээр ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж гэрээ байгуулах” ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгээс хөрөнгө оруулагчтай хийх хэлэлцээрүүд үргэлжилж байна. Таван толгойн 450 МВт-ын цахилгаан станцын төсөлд Японы Марубени компани “М Си Эс Повер” ХХК-ын хамтарсан туншлал, “Оюутолгой” ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлэлцэл хийж байна. Олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудтай гэрээгээ эцэслээгүй байна. Гэрээ хийгдсний дараа санхүүгийн хаалт хийгдэнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар “Таван толгойн орд газрыг лэд бүтцийн хамт иж бүрнээр ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж гэрээ байгуулах” ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгээс хөрөнгө оруулагчтай хийх хэлэлцээрүүд үргэлжилж байна. Тавантолгойн орд газраас 2017 оны 9 сарын байдлаар нийт 13.6 сая тонн нүүрс экспортоод байна. УУХҮЯ-ны сайдаар ахлуулсан Гацууртын орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Хөрөнгө оруулалтын болон Орд ашиглах гэрээ байгуулах талаар хэлэлцээр хийх Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулаад байна. /Монгол улсын ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20 дугаар захирамжаар “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийх”, 21 дүгээр захирамжаар Орд ашиглах гэрээ байгуулах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгүүдийг тус тус байгуулсан. УУХҮ-ийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд лэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулагдсан ба “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентерагоулд Монголия” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсэг боловсруулж, “Сентерагоулд Монголия” ХХК-наас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн./</p> <p>Эрчим хүчний сайдын 2016 оны 119 дүгээр тушаалаар ДЦСIII-ын өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг ажиллан станцын өргөтгөлийн ажлын даалгаврыг боловсруулж баглуулсан. Тус станцын өргөтгөлийг-эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барьж байгуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоол гарсан. 2017 оны 3 дугаар сарын 06-ны өдөр нээлттэй тендер зарласан. Төслийн гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээг 2017 оны 06 дугаар сарын 12-ний өдөр гэрээг байгуулж, санхүүжилтийн нөхцөл болон эргэн төлөлтийн санхүүжилтийн талаар гэрээ байгуулулахаар Сангийн яаманд 06 сарын 29-ны өдөр а/2086 тоот албан бичгээр хүргүүлсэн. Сангийн яамнаас одоогоор ямар нэгэн хариу ирүүлээгүй, төсөлд шалгарсан компаниудаас Сангийн яамтай төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах гэрээг байгуулахад бэлэн байгаа тухайгаа бичгээр мэдэгдээд байна.</p> <p>Эрчим хүчний сайдын 2016 оны 119 дүгээр тушаалаар Чойбалсангийн станцын өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг ажиллан станцын өргөтгөлийн ажлын даалгаврыг боловсруулж, баглуулсан. Тус станцын өргөтгөлийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барьж байгуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоол гарсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 19 дүгээр тушаалаар байгуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр зарласан. Шалгарсан гүйцэтгэгч компанитай 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдөр гэрээг байгуулсан.</p>
----	---	---	--

41	<p>2.2.2. Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоог, Хөөг-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богдхан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх</p>	<p>УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг тогтоосон. Үүнтэй холбоотойгоор тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловруулах шаардлага үүссэн бөгөөд ТЭЗҮ-ийг шинэчлэн боловруулах санхүүжилтгүйн улмаас зогсонги байна. Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Тавантолгойн орд газар болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор гадаад дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийж байна. Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 09-ний 222 дугаар тогтоолоор ТТ-Г Сухайт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлэх 400 сая ам.долларын санхүүжилтийг Хятад улсаас авах 1 тэрбум ам.долларын зээлд хамруулахаар шийдвэрлээд байна.</p> <p>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг 2008 онд БНХАУ-ын зураг төслийг 3 дугаар хүрээлэн боловруулж хүлээлгэн өгсөн. "Монголын-Алт" ХХК нь өөрийн санхүүжилтээр "Мөнгөн зөрлөг" ХХК-аар ТЭЗҮ-ийг шинэчлүүлсэн. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг Засгийн газрын хуралдаанаар баглуулахаар тогтоолын төслийг боловруулж яамдуудаас санал авахаар ажиллаж байна. Мөн царигийн өргөний хэмжээг тогтоолохоор УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловруулж байна. Тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг тогтоох УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн барих нь зүйтэй гэсэн 35 дугаар тэмдэглэл гарсан. Хөөг-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Байшинь төмөр зам компанийн захиалгаар БНХАУ-ын зураг төслийг 3 дугаар хүрээлэн боловруулж дуусгасан.</p> <p>Хөөг-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажлыг эхлүүлэхэд бэлэн болоод байна.</p> <p>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын чиглэлийг баглуулахаар УИХ-ын тогтоолын төслийг боловруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд энэ хаврын УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Си Ар И Си" компани өөрийн зардлаар боловруулж, 2017 оны 10 дугаар сарын сүүлээр "Монголын төмөр зам" ТӨХК-д хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. ТЭЗҮ, зураг төслийг боловруулсны дараа барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажлыг эхлүүлнэ.</p> <p>АХБ-ны техникийн туслалцааны 1.5 сая ам.долларын санхүүжилтээр "Богдхан төмөр зам"-ын чигийн судалгаа, ТЭЗҮ, зураг төслийг боловруулахаар ажиллаж байна. Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцааны хүрээнд чигийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээний компанийг шалгаруулж 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Энэтхэг улсын "ICT" компанитай гэрээ байгуулсан.</p>	40
----	--	--	----

<p>2.2.3. Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах хүрээнд цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх</p>	<p>Дарханы ДЦС-ын өргөтгөл: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 18 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр олон улсын хязгаарлагдмал тендерийг зарлаж 11 дүгээр сарын 29-ний өдөр тендерийг нээсэн. Гүйцэтгэгчээр БНХАУ-ын ТЕРС компани шалгарч 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр гэрээ хийсэн. ХБНГУ-ын KfW банк болон улсын төсвөөс санхүүжилт хийгдэнэ. Төслийг дуусгахад шаардлагатай байгаа 5.0 сая еврогийн нэмэлт зээлийн гэрээнд 2017 оны 06 дугаар сард Сангийн сайд гарын үсэг зурсан. Одоогоор гүйцэтгэгч БНХАУ-ын ТЕРС компаниас эхний ээлжинд 69 хүн ирж ажлын зурагтай танилцаж дотоодоос болон гадаадаас авах материал тоног төхөөрөмжийн захиалгын ажлыг хийж байна. /Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын Эрчим хүчний үр ашг-1 хөтөлбөрийн хүрээнд “Дарханы дулааны цахилгаан станцын турбиныг шинэчлэх” төслийг 2012 оноос эхлэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байна.</p> <p>Эрдэнэт ДЦС-ын өргөтгөл: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 17 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр олон улсын хязгаарлагдмал тендерийг зарлаж 10 дугаар сарын 20-ны өдөр тендерийг нээсэн. Үнэлгээний хороо үнэлж гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулсан. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт Импортын банкны хооронд байгуулсан зээлийн ерөнхий гэрээний дагуу төсөл болон төслийн гүйцэтгэгчээр шалгарсан компанид аудит хийх ажил явагдаж байна. Төслийн ажлыг 2017 онд эхлүүлж, 2018 онд дуусган ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.</p> <p>Эгийн голын цахилгаан станц: Усан цахилгаан станц барих ажлын хүрээнд байгаль орчны чиглэлээр дараахь судалгааны ажлуудыг хийсэн.</p> <p>- УЦС-ын болон дэд бүтцийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнүүдийг боловсруулан 2014 оны 9-10 сард Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлөөр тус тус багтуулсан. 2014-2015 онуудад Загас болон усны амьтдын амьдрах орчныг хамгаалах судалгааг явуулж, ЭГУЦС-ын далайд цуглуулах-зөөх төрлийн загас өнгөрүүлэх байгууламжийг төлөвлөсөн. 2014 онд ойн тооллого, судалгаа явуулсан. Судалгааны дүгнэлт зөвлөмжийн дагуу 6 га зулзаган модыг шилжүүлж, 14 га унанги болон шатсан ойг цэвэрлэсэн. Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу 2014 онд археологи, палеонтологийн хайгуул судалгаа явуулсан. Хайгуулаар илэрсэн 440 дурсгалыг 2014-2015 онуудад авран хамгаалсан. Мөн 2015 онд угсаатны зүйн судалгаа явуулсан. Хантай багийн шинэ байршлыг тодорхойлж, уг байрлалд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, инженер геологийн судалгаа хийсэн. Судалгаануудыг дүгнэлтэд үндэслэн Хантай багийн шинэ байршлын Ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. Ус цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран Эг, Сэлэнгэ мөрний сав газрын дагуух урсачын мэдээллийг шинэчлэн өргөтгөх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Эгийн голын УЦС далан байрлах хөндлүүрээс Сэлэнгэ мөрөн хүртлэх 2,5 км зайд мөсний зузааныг хэмжих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэлхийн Банкны санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Сэлэнгэ мөрөн дээрх Шүрэнгийн УЦС, Орхон гол дээрх Орхон-Говь цогцолбор төслийн ТЭЗҮ болон БОННУ боловсруулах судалгааны ажил, ЮНЕСКО-ын ДӨХ-өөс үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх талаар ГХЯ, ЭХЯ, БОАЖЯ хамтран байгуулсан ажлын хэсэг цаашид авах арга хэмжээ болон төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Орхон, Шүрэнгийн усны барилга байгууламж төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын даалгаврын төслийг ОХУ-ын БНБуриад Улс болон Эрхүү мужийн ард иргэдийн дунд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг хийх Ажлын хэсгийг БОАЖЯ-ны ТНБД-ын А/91 тоог тушаалаар байгуулсны дагуу 2017 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд ОХУ-ын</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>
--	--	---------------------------------------

<p>Эрхүү мужийн 3 суурин газар (Слюдянка, Ольхон, Эрхүү хог) ын ард иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийсэн. Буриад улсын нутаг дэвсгэрт 2017 оны 3 болон 5 сард зохион байгуулсан ард иргэд, төрийн , төрийн бус байгууллагуудын санал зөвлөмжийг Ажлын даалгаварт тусгах зорилгоор зохион байгуулсан нийт 2 удаагийн олон нийтийн хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг төлөөлсөн 1300 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгийг БНБУ-ын Байгалийн нөөцийн яамны дэмжлэгтэйгээр Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгжээс Буриад улсын 14 хот, тосгон, суурин газруудад зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч James Anderson дүгнэж хэлэхдээ ОХУ-д болсон хэлэлцүүлэг амжилттай болсоныг онцлон дурдсан. Эгийн голын УЦС ТӨХК байгуулагдан ОХУ-тай яриа хэлэлцээ хийх, судалгаа хийх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Ховд голын УЦС: Усан цахилгаан станц барих дараахь урьдчилсан судалгааны ажлууд хийсэн. Үүнд:</p> <p>- 2016 оны 5-10 дугаар сард төслийн талбар дээр өрөмдлөг, геологийн судалгаа хийсэн. Төслийн талбарын геотехник, топографийн судалгааны ажлыг Yooshin Engineering Corporation болон “Престиж Инженеринг” ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ болон ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн.</p> <p>БНХАУ-ын 2 компаниас төслийн нарийвчилсан ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ илэрхийлсэн. Төслийн техник, эдийн засгийн ЕРС+F зэрэг нөхцлөөр хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлсэн. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулахад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас авахаар ажиллаж байна.</p> <p>Чойрын 220 кВ-ын дэд станцын өргөтгөл: Чойр дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барьж байгуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоол гарсан. 2013 онд концессын гэрээ байгуулах тендер зарлагдсан бөгөөд 2017 оны 3 сарын 30-ны өдөр барих-шилжүүлэх концессын гэрээ "Алтай Трест" ХХК-тай байгуулсан. 2018 оны 6 сарын 30-ны дотор дуусгах гэрээтэй.</p> <p>Нийт хөрөнгө оруулалт нь 31,798,194 ам.доллартай тэнцэх төгрөг.</p> <p>Төсөвт 2019-2020 онуудад эргэн төлөгдөөр тусгагдана. Барилга угсралтын ажил эхэлсэн. Газар шорооны ажил болон тоног төхөөрөмжийн угсралтын бэлтгэл ажил дууссан, ажлын явц 40%-тай байна.</p> <p>Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын овортой 2 хэлхээт 260 км цахилгаан дамжуулах агаарын шугам: БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсад олгож буй 1.0 тэрбум ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс хэрэгжүүлэх “Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд барих” төслийн гүйцэтгэгчээр ТВЕА компанигай барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тус төслийн байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг дэмжсэнээр зохих журмын дагуу БНХАУ-ын ЭКЗИМ банкинд хүргүүлсэн. Сангийн яам ба БНХАУ-ын Экспорт импортын банкны хооронд зээлийн тусгайлсан гэрээг байгуулсан. 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр шугамын барилга угсралтын ажлын нээлтийг барилгын талбай дээр хийсэн.</p> <p>Оюутолгой-Цагаан суврагын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц: Уг төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл дуусч байгаа бөгөөд 220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцын 220 кВ талын өргөтгөл болох 220/110/35 кВ-ын 125 МВА трансформатор, 220 кВ-ын шугамын портал, таслуур болон бусад тоноглолууд, 220 кВ-ын 159.6 км ЦДАШ, 220/22-ын Цагаансуварга дэд станцын 220 кВ, 22 кВ талын таслуур, хүчдэл, гүйдлийн трансформатор зэрэг тоноглол болон 220/22 кВ-ын 2Х75 МВА трансформаторын угсралтын ажил бүрэн хийгдсэн. Эрчим хүчний хөгжлийн төвөөс 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс 15-ны өдрүүдэд хийсэн томиолтын ажлын хугацаанд туслан гүйцэтгэгч байгууллагуудын төлөөллийг байлцуулан дутуу болон хийгдээгүй барилга угсралтын ажлуудын жагсаалт</p>	<p>Хугацаа болоогүй</p>
---	-------------------------

43	<p>гарган, хэсэгчилсэн байдлаар техникийн комисс ажиллуулахаар дүгнэлт гаргасан байх бөгөөд үүнийг үндэслэн 2017 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс техникийн комисс ажиллаж, 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдөр төвийн эрчим хүчний системд холбогдоогүй байсан Дорноговь аймгийн Мандалх, Хаганбулаг сумдыг эрчим хүчинд холбосон. 2017 оны 10 дугаар сард багтаан улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>		
44	<p>2.2.4. Томоохон үйлдвэрлэлээ дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластерыг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p>“Жимс жимсгэнэ” хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах санхүүжилтийн тооцоог гаргаж Засгийн газарт хүргүүлэхэд бэлэн болгосон.</p> <p>АХБ-ны “ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцаа-ТА 8960 MON “ төслийн хүрээнд чацарганы нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг хэрэгжиж эхэлсэн.</p>	40
44	<p>2.2.5. Хөшигийн хөндийд баригдаж байгаа Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлэх</p>	<p>“Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төв аймгийн Засаг дарга нараар 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдөр батлуулсан.</p> <p>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 105 дугаар тогтоолыг баталсан. Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол болон хот байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 8 дахь заалтад Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулахтай холбогдуулан Засгийн газрын гишүүдэд даалгасан дээр дурдсан арга хэмжээнүүдэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд тус тус даалгасан. БХБЯ-аас асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж 2017 оны 3-р сарын 29-ний өдрийн 105-р тогтоолыг батлуулж шинэ хот байгуулах ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулахад нийслэлийн төсвөөс 633.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.</p>	40

45	2.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх	2.3.1. Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн төсөл дэх үндсэн хязгааруудыг (төсвийн алдагдал, орлого, зарлага болон эрийн дээд хэмжээ г.м) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад нэмэгдүүлэхгүй байхаар хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлагдсан Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголоор ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төлөвлөлтөд оролцох оролцоог зохистой түвшинд хязгаарлахаар болсон. Дээрх ажлын хүрээнд төсвийн сахилга багыг чанд сахих, төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тохирсны дотор Төсвийн зөвлөл байгуулах, уг зөвлөл нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахаар зохицуулагдсан. Түүнчлэн Засгийн газрын өргөн мэдүүлсэн нийт зарлагыг УИХ нэмэгдүүлэхээс сэргийлэх үүднээс холбогдох хуулийн өөрчлөлтүүдийг боловсруулан Монгол Улсын 2018 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх үүргийг ОУВС-ийн өмнө Засгийн газар хүлээн ажиллаж байна. ОУВС-тай тохирсны дагуу, тус байгууллагын зөвлөмжийг авах зорилгоор УИХ-ын төсвийн төлөвлөлтөд оролцох оролцоог зохистой түвшинд хязгаарлах хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх ажил энэ оны 10 сар хүртэл түр хойшиглогдоод байна.	40
46	2.3.2.Төв банкны засаглалын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх, Монголбанкны удирдлагын харааг бус байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, Монголбанкны үйл ажиллагааг тодорхой болгох чиглэлээр Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах	Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг Хууль тогтоомжид заасны дагуу боловсруулан УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшинд уламжилсан бөгөөд уг төсөлд Засгийн газраас 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцэж өгсөн саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэж байна.	70	
47	2.3.3.Валютын урсгалыг зохицуулах харилцааг сайжруулах зорилгоор Валютын зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж баглуулах	Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2017 оны 1 дүгээр сараас эхлэн “Валютын зохицуулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэгт Санхүүгийн Зохицуулах Хорооноос ажиллаж байна. 2017 оны эхнээс Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд заасны дагуу Валютын зохицуулалтын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Тус тандан судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан болно. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгаа, хуультай холбогдон гарах зардлын тооцоо, хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж байна. 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр СЗХ, банкуудтай хэлэлцүүлэг уулзалт хийсэн. Одоогоор хуулийг шинэчлэн найруулах ажлыг гүйцэтгэж байна.	70	

48	2.3.4. Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт болгох, болзошгүй эрсдэлийг үнэлэх, хамгаалах, бодлогын уялдааг хангах инстигуут болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах	Санхүүгийн Зохицуулах Хорооны газруудыг хамарсан ажлын хэсгийг байгуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэсэн. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санхүүгийн салбарт оролцогч Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоод, Даатгалын компаниуд, Үнэг цаасны салбарын оролцогчид, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоод, бусад төрийн байгууллагуудыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эдгээр ажлын дүнд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.	70
49	2.3.5. Хөгжлийн банкны улсын төсөвтэй харилцах харилцааг боловсронгуй болгох, болзошгүй эрсдэлийг бууруулах, засаглал, ил тод байдал, тайлагналыг сайжруулах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн батлуулж, бүтцийн өөрчлөлт хийх	Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварыг сайжруулах, улсын төсөв, Хөгжлийн банк хоорондын өр, авлагын тооцоотой холбогдох асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хөгжлийн банк, Сангийн яамнаас хамтран УИХ-ын "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг боловсруулсан ба уг тогтоолын төслийг Засгийн газраас 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Улмаар 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг баталсан. Банкны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан ба 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	70
50	2.3.6. Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж батлуулах	СТБЗ-ийн Ажлын албанаас "Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн концепцийн саналыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2017.01.24-ний өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж, уг хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017.01.30-ны өдрийн А-35/33/64 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2017.03.31, 2017.04.21, 2017.05.12-ны өдрүүдэд зохион байгуулж санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх, цаашин авах арга хэмжээний санал, хөтөлбөр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж, хөтөлбөрийн төслийг СТБЗ-ийн 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас гарсан санал зөвлөмжийг хөтөлбөрийн төсөлд тусган, баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулсан ба Сангийн яам 2017.06.29-ний өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж улмаар хөтөлбөрийг Засгийн газрын хуралд танилцуулан батлуулаад байна.	100

<p>2.3.7. Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, мэргэжлийн хяналт, татвар, нийгмийн даатгал, хууль хяналтын байгууллагын давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах</p>	<p>Банкнаас бусад санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийг цэгцлэх, олон тооны журмын зохицуулалтыг нэгтгэх, шаардлага нөхцөлийг уян хатан болгох, давхардлыг арилгаж, бүрдүүлж ирүүлэх шаардлагатай баримт бичгүүдийг багасгах чиглэлээр тусгай зөвшөөрлийн болон бүртгэлийн журам, дүрмийг шинэчлэхээр ажиллаж байна. Барилгын салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн судалгааг гартсан. 2017.03.01-ний байдлаар барилга байгууламжийн угсралтын ажлын хүрээнд 4204, Зураг төсөл боловсруулах 625, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл засвар үйлчилгээ эрхлэх 158, Барилгын материалын 726 аж ахуйн нэгж байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажил эрчимтэй явагдаж байгаа бөгөөд цаас үйлдвэрлэлийг багасгаж, тусгай зөвшөөрлийн тоог багасгах чанартай ийнженер техникийн ажилтнуудтай байгууллагад боломж олгох, Аж ахуйн нэгж байгууллагуудаас тусгай зөвшөөрлийн тайлан мэдээ авдаг байсан 33 төрлийн маягтийн тоог 11 төрлийн маягт болгон ажиллаж байна. Мөн тусгай зөвшөөрлийн журмыг шинэчлэн боловсруулж байгуулж байгаа бөгөөд тус журмаас барилгын засал чимэглэлийн тусгай зөвшөөрлийн заалтыг хасч тусгай зөвшөөрлийн тоог багасгах боллого барин ажиллаж байна. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд тавигддаг дүрэм, журмын шаардлагуудыг уян хатан байлгах замаар зохистой зохицуулалтын тогтолцоог бий болгох үүднээс:</p> <p>1. Хуулийн төслийг боловсруулах чиглэлээр хөрөнгө оруулалтын сан, менежментийн компани, брокер, дилерийн компанийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг 2017 оны 2 дугаар сард зохион байгуулж, холбогдох саналыг авав.</p> <p>2. Хорооноос ББСБ-ын үйл ажиллагааг зохицуулж байсан 4 журам, 1 зааврыг нэгтгэн “ББСБ-ын үйл ажиллагааны зохицуулалтын журам” шинэчлэн баталсан. Энэхүү журмыг шинэчлэн баталснаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагуудын стандарт, ангилал, эрхлэх үйл ажиллагааны төрөл, чиглэлтэй нь нийцүүлэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан 10 төрлийн үйл ажиллагааг төрөлжүүлэн 3 ангилж, тэдгээрт тавигдах шаардлага, заавал мөрдөх хэм хэмжээ, зохистой харьцааг илүү оновчтой тогтоох, зохицуулалт, хяналт шалгалт хийх тогтолцоог бий болгосон. Санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогч байгууллагууд нэгдэх, нийлэх замаар чадавхи дээшлүүлэхийг дэмжих арга хэмжээ авсан. 1/ Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг улс орны эдийн засаг болон ҮЦК-уудын үйл ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан тогтоож, хэрэгжилтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна. Энэ нь салбарын мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхижуулахад чухал ач холбогдолтой болсон. Хорооны зүгээс Хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэгдүүлэх зорилгоор нэгдэх, нийлэх арга хэмжээг дэмжиж ажиллаж байна. 2/ ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчилэн тогтоосонтой холбоотойгоор Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг чадавхижуулах зорилгоор дөрвөн банк бус санхүүгийн байгууллага хоорондоо нэгдэх үйл ажиллагаа явагдаж байна.</p>	70
--	--	----

<p>2.3.8. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг мэргэшсэн, хариуцлагатай, цомхон, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>Төрийн албан хаагчийн цалин хөлсний тогтолцоог шинэчлэх чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлээд байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ангилал зэрэглэлийг боловсронгуй болгох зорилг тусгагдан хэрэгжиж байна. Хөдөлмөр, нийгмийн зөвшллийн турван талт 2017-2018 оны Улсын хэлэлцээрт төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох, шинэчлэх ажлыг үе шатай хэрэгжүүлэх арга хэмжээ тусгуулж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2017 онд эрүүл мэндийн салбарын, 2018 онд боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилал, зэрэглэлийг шинэчлэхээр тусгасан. Үүний дагуу эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үр чадвар, мэдлэг, хүлээх үүрэг хариуцлага, хөдөлмөрийн нөхцөл болон ажлын ачааллыг харгалзаж, ажлын байранд суурилсан тогтолцоо нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар 2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүнгийн талаар нэрийнчилсэн төлөвлөгөө, Ажлын хэсгийн байгуулав. Төлөвлөгөөний дагуу олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр хамтарсан тушаалаар удирдаж, ажлын байрны үнэлгээ хийх арга зүй, аргачлалын төслийг боловсруулан Эрүүл мэндийн яаманд хөгжүүлж батлуулахад болон Түүнчлэн СУХБ-аас палин хөлсний шинэ</p>	40
---	--	----

53	2.3.9. Тодорхой эрхэлсэн ажилгүй иргэдийг богино хугацааны цагийн ажилд зуучлах, цалин хөлсийг тухай бүр олгох боломжийг бүрдүүлэх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрөөс “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-г бүртгэлтэй ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах, орлогоор дэмжих зорилго бүхий нийтийг хамарсан ажил, цагийн ажилд зуучлах, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах зэрэг арга хэмжээнүүд туссан. Уг арга хэмжээнүүдийн хүрээнд 2017 онд 3.0 тэрбум төгрөгийг зарцуулж 24600 орчим иргэнийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	40	
54	2.3.10. Ажлын байрны эрэлт, хэрэгцээнд үндэслэн богино хугацаанд мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчийг бэлтгэх	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрөөс “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-г хөдөлмөр эрхлэлтийн болон үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах арга хэмжээнүүд туссан. Уг арга хэмжээнүүдийн хүрээнд 2017 онд 1.8 тэрбум төгрөгийг зарцуулж 8000 орчим иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, хөдөлмөрт бэлтгэн, тогтвортой ажлын байранд зуучлахаар ажиллаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх хяналтын тоог Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйл, Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/197 тоот тушаалаар баталсан Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам, Барометрийн судалгаа /2016 он/, Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн тогтоолоо. 2016-2017 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтын 90 байгууллагын 26711 суралцагчдыг элсүүлэх хяналтын тоо, квот батлагдаж байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 82 сургалтын байгууллагад 27680 суралцагч элсүүлэх квотын санал ирүүдсэн нь өмнөх оны батлагдсан квотоос 969 суралцагчаар илүү байна.	40	

Тогтоолоог судалж нэвтрүүлэх талаар зөвлөгөө авч ажиллаж байна.